



*МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН*  
**2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН**

*2023 ОНЫ 7 ДУГААР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ*

# **ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ**

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРОО**

## **ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС**

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН  
АГУУЛГА**

**2023 оны 7 дугаар сарын 04-ний өдөр, Мягмар гараг**

<b>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</b>	1
<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>	2 - 11
<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>	12 - 61

---

1. **“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл /Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн хэрэгжилтийг хянан шалгах, эдгээр сангуудад байршиж байгаа мөнгөн хөрөнгийн төвлөрүүлэлт, зарцуулалт, эрсдэлээс хамгаалах талаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий/** 13
2. **Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.05.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/** 14 - 21
3. **Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/** 22 - 26
4. **Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2023.06.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/** 26 - 57
5. **Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, “Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.06.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ/** 57 - 61

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы  
Эдийн засгийн байнгын хорооны 7 дугаар сарын 04-ний өдөр  
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 18 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 55.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 40 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Энхбаяр;

Чөлөөтэй: Б.Жавхлан, М.Оюунчимэг, С.Чинзориг;

Эмнэлгийн чөлөөтэй: Н.Ганибал.

Хэлэлцэх асуудлын дараалалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг “Ажлын хэсэг байгуулах тухай тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэх асуудлын дараалалд оруулах гэсэн горимын санал гаргав.

**Ц.Цэрэнпунцаг:** Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 4

Бүгд: 10

60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Нэг. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл**  
*/Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн хэрэгжилтийг хянан шалгах, эдгээр сангуудад байршиж байгаа мөнгөн хөрөнгийн төвлөрүүлэлт, зарцуулалт, эрсдэлээс хамгаалах талаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий/*

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, мөн хэлтсийн референт А.Хонгорзул нар байлцав.

**Ц.Цэрэнпунцаг:** Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн хэрэгжилтийг хянан шалгах, эдгээр сангуудад байршиж байгаа мөнгөн хөрөнгийн төвлөрүүлэлт, зарцуулалт, эрсдэлээс хамгаалах талаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5

Татгалзсан: 5

Бүгд: 10

50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Ц.Цэрэнпунцаг:** Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Ц.Цэрэнпунцаг:** “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 3  
Бүгд: 10  
70.0 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

*Уг асуудлыг 11 цаг 45 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр.Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.05.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн дэд сайд Л.Халтар, Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга С.Мяндасмаа, Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Ч.Мөнхтуяа, Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөх Д.Эрдэнэбат, Иргэний нисэхийн ерөнхий газрын Нисэхийн аюулгүй ажиллагаа хяналт, зохицуулалтын албаны дарга П.Ганболд, Иргэний нисэхийн үндэсний төвийн дарга Н.Батсайхан, мөн төвийн Захиргаа, хүний нөөцийн газрын менежер З.Туяа, Зам, тээврийн хөгжлийн сайдын туслах П.Тамир нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, мөн хэлтсийн референт А.Хонгорзул нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

**ИРГЭНИЙ НИСЭХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН  
ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ТАЛААРХ  
ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН  
ТОМЬЁОЛОЛ:**

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед тухайн зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалгаагүйгээр уг асуудлыг гүйцээн боловсруулж, төслийн холбогдох зүйл, хэсэг, заалттай уялдуулахаар Байнгын хороонд шилжүүлсэний дагуу санал хураалт явуулав.*

**Ц.Цэрэнпунцаг:** 1.Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, Б.Баттөмөр, Н.Ганибал, М.Оюунчимэг, Б.Энхбаяр /Цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “Монгол Улсын олон улсын гэрээнд” гэснийг “конвенцын хавсралтад” гэж, 12.1.1 дэх заалтын “тайлбар” гэснийг “тайлбарыг батлах” гэж, 12.1.6 дахь заалтын “дүрэм” гэснийг “шаардлага тогтоох” гэж, 12.1.7 дахь заалтын “тогтолцооны нийтлэг зохицуулалт” гэснийг “тогтолцоог хэрэгжүүлэх” гэж, 12.1.11 дэх заалтын “тээвэрлэгчийн гэрчилгээжүүлэлт” гэснийг “тээвэрлэгчийг гэрчилгээжүүлэх” гэж, 12.1.17 дахь заалтын “хөлөг болон нисэх клубийн гэрчилгээжүүлэлт” гэснийг “хөлгөөр сонирхогчийн үйл ажиллагаа эрхлэгчийг гэрчилгээжүүлэх” гэж тус тус өөрчилж, 12.1.8 дахь заалтын “хүнгүй агаарын хөлөг, аргамжаат шүхэр болон” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 3  
Бүгд: 10  
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.1.2, 12.1.3, 12.1.4 дэх заалтыг 12.1.2, 12.1.3, 12.1.4, 12.1.5, 12.1.6 дахь заалт болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.1.2.Монгол Улсад иргэний агаарын хөлгийг бүртгэх, нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ олгох, агаарын хөлөг, бүтээгдэхүүн, эд ангийг гэрчилгээжүүлэх, нислэгт тэнцэх чадварын удирдамж гаргах, техникийн үйлчилгээний ерөнхий шаардлагыг тогтоох;

12.1.3.хувь хүнд мэргэжлийн үнэмлэх, зэрэглэл, эрүүл мэндийн гэрчилгээ олгох;

12.1.4.ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагаа эрхлэх;

12.1.5.иргэний нисэхийн дүрмийг албадан хэрэгжүүлэх, дүрмийн шаардлагаас чөлөөлөх;

12.1.6.осол, зөрчлийг мэдээлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 3  
Бүгд: 10

70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэний дагуу санал хураалт явуулав.*

**Ц.Цэрэнпунцаг:** 3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсгийн “14.1,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 3

Бүгд: 10

70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

**АГААРЫН ЗАЙГ НИСЭХЭД АШИГЛАХ ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ  
ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН  
ТОМЬЁОЛОЛ:**

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-д нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэний дагуу санал хураалт явуулав.*

**Ц.Цэрэнпунцаг:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “Иргэний нисэхийн тухай хуулийн 7.1.3-т” гэснийг “Иргэний нисэхийн тухай хуулийн 7.1.3-т заасны дагуу тогтоох бөгөөд уг асуудлаар батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас санал авсан байна” гэж, мөн зүйлийн “Иргэний нисэхийн тухай хуулийн 8.1.7-д” гэснийг “Иргэний нисэхийн тухай хуулийн 8.1.7-д заасны дагуу тогтооно” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 3

Бүгд: 10

70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 9 дүгээр зүйлд Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага Засгийн газрын тохируулагч агентлаг байх зохицуулалт тусгагдсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийг үндэслэн боловсруулсан “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулав.

Байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг Тогтоолын төслийг Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт батлах шаардлагатай тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.22 дахь хэсгийг үндэслэн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах гэсэн горимын санал гаргав.

**Ц.Цэрэнпунцаг:** Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн:	7
Татгалзсан:	3
Бүгд:	10

70.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлэг, тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 12 цаг 12 минутад хэлэлцэж дуусав.*

***Гурав.Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн дэд сайд Л.Халтар, Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, мөн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэлтсийн дарга Д.Жавхлан, Хуулийн хэлтсийн дарга С.Мяндасмаа, Төмөр зам, далайн тээврийн Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын шинжээч Н.Наранчимэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, мөн хэлтсийн референт А.Хонгорзул нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягийн тавьсан асуултад Зам, тээврийн хөгжлийн дэд сайд Л.Халтар хариулж, тайлбар хийв.

**Нэг.ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬ  
/ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ  
ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН  
ТОМЬЁОЛОЛ:**

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэний дагуу санал хураалт явуулав.*

**Ц.Цэрэнпунцаг:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсгийн “суурь бүтэцтэй огтлолцох” гэснийг “суурь бүтэцтэй ижил бус түвшинд огтлолцох” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 3  
Бүгд: 10  
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

**Хоёр.ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬ  
/ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ИЙН ТӨСӨЛТЭЙ ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН  
УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ  
ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН  
ТОМЬЁОЛОЛ:**

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэний дагуу санал хураалт явуулав.*

**Ц.Цэрэнпунцаг:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “29.1.12” гэснийг “29.1.13” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 3  
Бүгд: 10  
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“3 дугаар зүйл.**Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “29.1.1, 29.1.2, 29.1.3,” гэснийг хассугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.



Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 3  
Бүгд: 10  
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 10 дугаар зүйлд төмөр замын тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг байх зохицуулалт тусгагдсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийг үндэслэн боловсруулсан “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулав.

Байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг тогтоолын төслийг Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт батлах шаардлагатай тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.22 дахь хэсгийг үндэслэн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах гэсэн горимын санал гаргав.

**Ц.Цэрэнпунцаг:** Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 5  
Бүгд: 10  
70.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Ц.Цэрэнпунцаг:** Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 3  
Бүгд: 10  
70.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Ц.Цэрэнпунцаг:** Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцагийн гаргасан, “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах гэсэн горимын саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 3

Бүгд: 10  
70.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлэг, тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 12 цаг 29 минутад хэлэлцэж дуусав.*

***Дөрөв.Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2023.06.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Эдийн засаг, хөгжлийн дэд сайд Г.Түвдэндорж, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Анар, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Төслийн санхүүжилтийн хэлтсийн дарга Ш.Маргад, Хөрөнгө оруулалтын бодлогын газрын зөвлөх С.Пүрэвсүрэн, Э.Цацрал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Золжаргал, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, мөн хэлтсийн референт А.Хонгорзул нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам, Т.Аубакир, Ж.Бат-Эрдэнэ, Д.Батлут, Х.Ганхуяг, О.Цогтгэрэл, Т.Доржханд нарын тавьсан асуултад Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Т.Доржханд, Ц.Цэрэнпунцаг нар үг хэлэв.

**Ц.Цэрэнпунцаг:** Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 4  
Бүгд: 12  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

**Ц.Цэрэнпунцаг:** Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 5

Бүгд: 12

58.3 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 14 цаг 00 минутад хэлэлцэж дуусав.*

**Тав.Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, “Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.06.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Сангийн сайд Б.Жавхлан, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Наранчимэг, Аудитын нэгдсэн удирдлага зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, мөн хэлтсийн референт А.Хонгорзул нар байлцав.

Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Наранчимэг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 14 цаг 17 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 2 цаг 38 минут үргэлжилж, 18 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 72.2 хувийн ирцтэйгээр 14 цаг 18 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ДАРГА

Ц.ЦЭРЭНПУНЦАГ

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ  
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2023 оны 7 дугаар сарын 04-ний өдөр,  
Мягмар гараг  
Төрийн ордны “Их засаг” танхим  
11 цаг 40 минут

### **БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Ц.Цэрэнпунцаг:** Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя. Наянтайн Ганибал гишүүн өвчтэй, Төмөртогоогийн Энхтүвшин гишүүн өвчтэй, М.Оюунчимэг гишүүн чөлөөтэй. Батгөмөрийн Энхбаяр гишүүн гадаад томилолттой.

Ингээд Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж Байнгын хорооны ирц 55.6 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2023 оны 7 дугаар сарын 04-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Хэлэлцэх асуудал.

Нэг.Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Засгийн газар 2023 оны 5 дугаар сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн. Эцсийн хэлэлцүүлэг.

Хоёр.Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Засгийн газар 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр өргөн мэдүүлсэн. Эцсийн хэлэлцүүлэг.

Гурав.Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд.

Засгийн газар 2023 оны 6 сарын 23-ны өдөр өргөн мэдүүлсэн. Хэлэлцэх эсэх.

Дөрөв.Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, “Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Засгийн газар 2023 оны 6 дугаар сарын 16-ны өдөр өргөн мэдүүлсэн. Хоёр дахь хэлэлцүүлэг.

Санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ гэсэн ийм дөрвөн асуудлыг өнөөдөр Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу? Х.Ганхуяг гишүүн саналаа хэлье.

**Х.Ганхуяг:** Өнгөрсөн 5 дугаар сард Эдийн засгийн байнгын хорооноос Засгийн газрын тусгай сангуудыг шалгах ажлын хэсэг байгуулагдсан юм. Санал, дүгнэлт бэлтгэх.

Тэгээд 25 сантай юм билээ. Одоо дөнгөж 10-тай нь танилцаад л нөгөө хугацаа нь дуусчихсан. 6 сарын энэ чинь хэднээр байлаа. 13-наар байсан байх.

Тэгэхээр ерөөсөө ямар ч тийм шалгах боломж ч гарсангүй, танилцах боломж ч гарсангүй.

Тэгэхээр энэ хугацааг сунгаж өгөх асуудлыг Байнгын хорооны даргаас хүссэн. Гишүүдээсээ бас хүсэх гэсэн юм.

11 сарын 15, 20 хүртэл сунгаж өгөхгүй бол яагаад ч үзэж амжихгүй юм билээ. 11 сарын 20. Тийм.

Тэгээд намрын чуулганаар Байнгын хороон дээр санал, дүгнэлтээ танилцуулах ийм л асуудал.

Тэгэхгүй бол энэ дээр санал, дүгнэлт бэлдэх ямар ч боломж алга.

**Ц.Цэрэнпунцаг:** Х.Ганхуяг гишүүний гаргасан саналыг ойлгож байна. Гарцаагүй шаардлага тулж байгаа.

Дээрээс нь энэ хаврын чуулган хаагдах дөхөж байгаа учраас ер нь өнөөдрийнхөө хэлэлцэх асуудалд нэмээд оруулчихъя.

Тэгээд Х.Ганхуяг гишүүний энэ сангуудын ажлыг шалгах ажлын хэсгийн ажиллах хугацааг сунгая, энэ асуудлыг өнөөдрийн хэлэлцэх асуудалд оруулъя гэдгээр санал хураалтыг эхлээд явуулчихъя.

Тэгвэл ингээд Х.Ганхуяг гишүүний саяын тайлбарласан асуудлыг өнөөдрийн хэлэлцэх асуудалд оруулъя гэсэн саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 60.0 хувь нь дэмжиж санал дэмжигдлээ.

---

**Нэг. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл**  
*/Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн хэрэгжилтийг хянан шалгах, эдгээр сангуудад байршиж байгаа мөнгөн хөрөнгийн төвлөрүүлэлт, зарцуулалт, эрсдэлээс хамгаалах талаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий/*

---

Санал дэмжигдсэн тул ажлын хэсгийн ажиллах хугацааг 2023 оны 11 сарын 20 хүртэл сунгая гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Миний энэ аппарат ажилласангүй. Саяын хураасан санал хураалтыг хүчингүй болгоод дахин санал хураалт явуулъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 60.0 хувь нь дэмжиж саяын санал хураалт хүчингүй боллоо.

Саяын уншсан саналыг дахин санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 70.0 хувь нь дэмжиж санал дэмжигдлээ.

Ингээд ажлын хэсгийн ажиллах хугацааг сунгасан.

Ингээд хэлэлцэх асуудалдаа орёе.

**Хоёр.Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл  
болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд**

*/Засгийн газар 2023.05.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/*

Нэг.Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийг оруулна уу. Төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ танилцуулна. Ж.Бат-Эрдэнэ гишүүний микрофоныг нээе.

**Ж.Бат-Эрдэнэ:** Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 5 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг 2023 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.1-д зааснаар хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулахаар өгсөн чиглэлийн дагуу төслийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгтэй холбогдуулан тус хэсэгт иргэний нисэхийн дүрмээр зохицуулах үйл ажиллагааны агуулгыг алдагдуулахгүйгээр өөрчлөн боловсруулж, үйл ажиллагаа хэлбэрээр томьёолох, түүнчлэн 12.1.2-12.1.4 дэх заалтад тусгагдсан үйл ажиллагааг

өөрчлөн найруулахтай холбогдсон 2 зарчмын зөрүүтэй санал бэлтгэлээ.

Мөн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.3 дахь заасны дагуу хураалгахаар Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан тус бүр нэг зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг бэлтгэлээ.

Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсэгт төслийн 14.1-д заасан Монгол Улсад бүртгэх агаарын хөлөг түүний бүрдэл хэсгийн бүртгэлд хэт хөнгөн агаарын хөлөг, агаарын бөмбөлөг болон агаарын хөлгийн загварын нислэг хамаарахгүйгээр тусгагдсан тул төслийн 15.5 дахь хэсэгт өөрчлөлт оруулж, “14.1” гэснийг хасах санал бэлтгэсэн болно.

Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хуулийн төсөлд Монгол Улсын агаарын хилээр агаарын хөлөг нэвтрэн орох, гарах цэгийг иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас санал авахаар давхардан тусгагдсан тул үүнийг нийцүүлэн өөрчлөх санал бэлтгэсэн болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Ажлын хэсгээс боловсруулан оруулж байгаа зарчмын зөрүүтэй саналыг

хэлэлцэн шийдвэрлэхийг Та бүхнээс хүсье. Баярлалаа.

**Ц.Цэрэнпунцаг:** Ж.Бат-Эрдэнэ гишүүнд баярлалаа. Ингээд ажлын хэсгийг танилцуулъя. Хаалт.

Лувсангийн Халтар Зам, тээврийн хөгжлийн дэд сайд, С.Батболд Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Сүхээгийн Мяндасмаа Зам, тээврийн хөгжлийн яамны Хуулийн хэлтсийн дарга, Чимэддоржийн Мөнхтуяа Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга, Доржийн Эрдэнэбат Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөх, Пүрэвжавын Ганболд Иргэний нисэхийн ерөнхий газрын Нисэхийн аюулгүй ажиллагаа хяналт, зохицуулалтын албаны дарга, Нямсамбуугийн Батсайхан Иргэний нисэхийн үндэсний төвийн дарга, Зинамидэрийн Туяа Иргэний нисэхийн үндэсний төвийн Захиргаа, хүний нөөцийн газрын менежер, Пүрэвсүрэнгийн Тамир Зам, тээврийн хөгжлийн сайдын туслах.

Ажлын хэсгийн танилцуулгаас асуух асуулттай Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалгаагүй нээлттэй үлдээсэн саналуудаар санал хураалт явуулж эхэлье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.1-д зааснаар хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулахаар өгсөн чиглэлийн дагуу хураалгах санал.

1.Төслийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “Монгол Улсын олон улсын гэрээнд” гэснийг “конвенцын

хавсралтад” гэж, 12.1.1 дэх заалтын “тайлбар” гэснийг “тайлбарыг батлах” гэж, 12.1.6 дахь заалтын “дүрэм” гэснийг “шаардлага тогтоох” гэж, 12.1.7 дахь заалтын “тогтолцооны нийтлэг зохицуулалт” гэснийг “тогтолцоог хэрэгжүүлэх” гэж, 12.1.11 дэх заалтын “тээвэрлэгчийн гэрчилгээжүүлэлт” гэснийг “тээвэрлэгчийг гэрчилгээжүүлэх” гэж, 12.1.17 дахь заалтын “хөлөг болон нисэх клубийн гэрчилгээжүүлэлт” гэснийг “хөлгөөр сонирхогчийн үйл ажиллагаа эрхлэгчийг гэрчилгээжүүлэх” гэж тус тус өөрчилж, 12.1.8 дахь заалтын “хүнгүй агаарын хөлөг, аргамжаат шүхэр болон” гэснийг хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, Б.Баттөмөр, Н.Ганибал, М.Оюунчимэг, Б.Энхбаяр. Цаашид “Ажлын хэсэг” гэх.

Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 70.0 хувь дэмжиж, санал дэмжигдлээ.

2.Төслийн 12 дугаар зүйлийн 12.1.2, 12.1.3, 12.1.4 дэх заалтыг 12.1.2, 12.1.3, 12.1.4, 12.1.5, 12.1.6 дахь заалт болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.1.2.Монгол Улсад иргэний агаарын хөлгийг бүртгэх, нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ олгох, агаарын хөлөг, бүтээгдэхүүн, эд ангийг гэрчилгээжүүлэх, нислэгт тэнцэх чадварын удирдамж гаргах, техник үйлчилгээний ерөнхий шаардлагыг тогтоох;

12.1.3.хувь хүнд мэргэжлийн үнэмлэх, зэрэглэл, эрүүл мэндийн гэрчилгээ олгох;

12.1.4.ерөнхий зохицуулалтын нисэхийн үйл ажиллагаа эрхлэх;



12.1.5.иргэний нисэхийн дүрмийг албадан хэрэгжүүлэх, дүрмийн шаардлагаас чөлөөлөх;

12.1.6.осол, зөрчлийг мэдээлэх;”

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалтыг зогсооё.

Х.Ганхуяг гишүүн асуултаа асууя.

**Х.Ганхуяг:** 12.1.2 дээр Монгол Улсад иргэний агаарын хөлгийг бүртгэх, нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ олгох, агаарын хөлөг гэрчилгээжүүлэх.

Үүнийг ойлгож л байна л даа. Тэгэхдээ “бүтээгдэхүүн, эд ангийн гэрчилгээжүүлнэ” гэдгийг нэг их сайн ойлгохгүй байна.

Энэ чинь үндсэндээ дахиад л хүнд суртлыг бий болгосон. Эд ангийг бүртгэлжүүлнэ, гэрчилгээжүүлнэ гэж юу байх вэ дээ.

Тэр чинь агуулахын бүртгэлийг хэлж байгаа юм уу, эсвэл эд анги болгон дээр нь гэрчилгээ олгоод явна гэж ярьж байгаа юм уу?

Тэгээд иргэний агаарын ямар нэгэн шинэ бүтээгдэхүүн гаргах болохоор дахиад л зөвшөөрөл авдаг.

Гэрчилгээтэй нэртэй зөвшөөрлийн маягийн шинж чанартай л юм оруулчихсан л юм надад харагдаад байгаа юм.

Үүнийг Ж.Бат-Эрдэнэ дарга надад нэг тайлбарлаад өгөөч.

Тэгээд техник ерөнхий шаардлагыг тавина гээд. Энэ гэрчилгээжүүлэлттэй холбоотой техникийн ерөнхий шаардлагыг тогтооно гээд л оруулчхаж байгаа юм л даа.

Тэгэхээр “бүтээгдэхүүн, эд анги дээр гэрчилгээжүүлэх ерөнхий шаардлагыг тогтооно” гээд. Энэ чинь үндсэндээ л зөвшөөрөл олгох гээд байгаа л.

Одоо энэ сэлбэг, эд анги дээр гэрчилгээ олгоно гэж яг юу гэсэн үг юм? Үүнийг нэг сайн ойлгохгүй байна.

Бүтээгдэхүүн дээр гэрчилгээ олгоно гэж юу гэсэн үг юм.

Ер нь бид хууль батлахдаа аль болох хүнд суртлыг багасгах тал руугаа л явдаг байхгүй бол энэ чинь эргээгээд л нөгөө бүтээгдэхүүний үнэ нэмэгдүүлэх, зардлыг нь нэмэгдүүлэх. Тэгээд л тэр чинь давхар дахиад л нэг хүн ажилладаг болно.

Тэгээд нөгөө яриад байгаа билетийн үнэ өснө гэдэг чинь нэг иймэрхүү юмтайгаа л холбоотой юм билээ шүү дээ. Ж.Бат-Эрдэнэ дарга. Та анхаарна биз. Тийм ээ.

**Ц.Цэрэнпунцаг:** Ж.Бат-Эрдэнэ гишүүн хариулья.

**Ж.Бат-Эрдэнэ:** Ер нь тантай санал нэг байгаа.

Иргэний агаарын тээврийн либералчлал гэдэг зүйлийг миний үед сайд байхдаа эхлүүлээд явж байсан юм.

Ер нь иргэний агаарын тээврийг либералчлах, аль болох хүнд суртал, элдэв янзын зөвшөөрлөөс болоод татгалзах талынх нь зүйлүүдийг хийж байгаа.

Гэхдээ энд бид түрүүн яригдаж байсан даа. Чуулган дээр ч яригдсан. Конвенц гээд. Энэ конвенцыг дагаж байгаа, дагаж явж байгаа 19 байдаг байх

аа. Хэд ч билээ баахан дагалдсан юуны дүрмүүд байж байгаа.

Тэгэхээр энэ дүрэм болгоноор саяын бидний хэлж байгаа иргэний агаарын хөлгийг бүртгэлжүүлэх, бүртгэх, нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ олгох, агаарын хөлөг, бүтээгдэхүүн, тэгээд эд ангийг хүртэл гэрчилгээжүүлэх гээд бүх тэр конвенцод заасан дүрмийнхээ дагуу зохицуулчхаад байгаа юм.

Тэгэхээр бид үүнийг яагаад ч өөрчлөх боломж бололцоогүй. Энэ конвенц, энэ дүрмүүдийг дагаж байж бид олон улстай харьцах. Угаасаа иргэний нисэх гэдэг чинь олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгддөг конвенцынхоо **ICAO /International Civil Aviation Organisation/-ын** тэр шаардлагуудыг дагаж бид тэмцэж, хамтарч ажиллах, харилцан бие биедээ нисэх боломж, бололцоо маань нээгдэх ёстой юм.

Тэгэхээр дээр тэр дүрмүүдийнхээ дагуу. Тэр тусмаа “эд анги” гэдэг асуудал болчихоод байна. Тийм үү. “Бүтээгдэхүүн, эд ангийг гэрчилгээжүүлэх” гэдэг дээр **П.Ганболд**, яамнаас тодорхой танилцуулга өгөөч ээ. Тийм. Ажлын хэсэг танилцуулгыг нь нэмээд өгчих. Тийм.

**Ц.Цэрэнпунцаг:** Ажлын хэсгийн 3 номер нэмж хариулья.

**П.Ганболд:** Х.Ганхуяг гишүүний асуултад хариулья. **П.Ганболд** Иргэний нисэхийн ерөнхий газрын Нисэхийн аюулгүй ажиллагааны Хяналт зохицуулалтын албаны дарга.

Сая таны асуусан асуулт дээр “эд ангийн бүртгэл” дээр “дангаараа онгоцны хөдөлгүүр”, “дангаараа онгоцны сэнсэнд парт номертой гэрчилгээжүүлдэг” учраас дагаж явдаг юм.

Сая гишүүн, ажлын хэсгийн ахлагчийн хэлснээр бид конвенцын хавсралтын дагуу. Тэгээд дангаараа заавал онгоцны хөдөлгүүр нь “сэнс” гэх мэтчилэн эд анги зүйлүүд гэрчилгээждэг учраас үүнийг нэмж оруулсан юм.

Бүтээгдэхүүн мөн дагаж явдаг. Нийт эд ангиа нийлүүлээд. Одоо жишээ нь, “сэнс, хөдөлгүүр” нийлснийгээ бүтээгдэхүүн гээд явчхаж байгаа юм. Нэр томьёо нь дээр.

**Ц.Цэрэнпунцаг:** Нэр томьёоны хувьд сонголт нь ямар байгаа юм. Бас нэг ойлгомжтой нэг мөр ойлголттой. Буруу зөрүү өөр ойлголтууд өгчхөж магадгүй л нэр томьёо юм байна шүү дээ. Түүн дээрээ.

Бүтээгдэхүүн гэдгээ хасаж болох юм уу? Болохгүй юм уу? Тэгвэл яах вэ, үүгээр нь.

Ажлын хэсгийн 3-аас дахиад хариулаадах. Яг “бүтээгдэхүүн” гэдгийг аваад хаячихвал ямар өөрчлөлт, агуулга нь яаж өөрчлөх гээд байгаа юм?

**П.Ганболд:** Бид олон улсын **Чикагогийн конвенц /Chicago Convention/-ын Annex 19** хавсралтуудаа дагаад дүрэм, журмаа гаргадаг.

Энэ дүрэм, журамд **Annex** дээр зааснаараа бүгд яг **“эд, анги бүтээгдэхүүн”** гэж үгээрээ явдаг юм.

Тэгэхээр бид хасчихаар нийлсэн эд, анги бүтээгдэхүүн нь хасагдлаа. Жишээ нь, ICAO-гийн шалгалтаас ирээд “үл тохирол” болоод явчихдаг байхгүй юу.

Жишээ нь, хууль дээрээ та нар гүйцэд зааж өгсөн юм уу, үгүй юу гэдэг. Баталгаат “эд ангиа” ашиглаж байгаа юм

уу, “бүтээгдэхүүн” гэж оруулсан юм уу гээд. Тэр үүднээс л бид.

Нэр томъёоны тодорхойлолтоор ороод явчихдаг юм.

**Ц.Цэрэнпунцаг:** Тэр нь тэгээд англиараа юу гэсэн үг байдаг юм? “Бүтээгдэхүүн” гэдэг нь.

**П.Ганболд:** “Spare parts”<sup>[сэлбэг хэрэгсэл]</sup>. Тэгээд дээр нь.

**Ц.Цэрэнпунцаг:** Тэр чинь манайхаар “запас сэлбэг” биз дээ?

**П.Ганболд:** Тийм. Запас сэлбэг. Тийм.

**Ц.Цэрэнпунцаг:** Тэгээд “бүтээгдэхүүн” гэдэг нь яг юу гэсэн үг юм? Та нар “бүтээгдэхүүн” гэж орчуулсан юм?

**П.Ганболд:** Яах вэ, “бүтээгдэхүүн” гэдэг дээрээ бид нарын ойлголтоор “сэнс, хөдөлгүүр” бүгдийг нь нийлүүлэхээр “бүтээгдэхүүн” болоод явчхаж байгаа.

**Ц.Цэрэнпунцаг:** Харин тэр нь яг англи дээр та нарын барьсан жишиг хууль дээр чинь юу гэсэн үг байсан юм бэ гэж асууж байна.

**П.Ганболд:** “Product” гэж явдаг юм л даа.

**Ц.Цэрэнпунцаг:** Эд анги. Тийм шүү дээ. Тэр чинь “бүтээгдэхүүн” гэхээр чинь энэ чинь бид нарт яагаад ч юм бидний хэл усанд байхгүй л үг, хэллэг болчихоод байна шүү дээ.

**П.Ганболд:** Яах вэ, тэгвэл бид “эд анги” гэдэг зүйлүүдээ л тодруулж өгөөд “бүтээгдэхүүнээ” хасчихвал бид болно л гэж ойлгох уу даа. Уг нь тэгж явдаг юм.

**Ц.Цэрэнпунцаг:** Тэгье. Бүтээгдэхүүнийг нь хасаад дахиад би уншъя. Тэгэх үү? Дахиад би бүтээгдэхүүнийг хасаж уншъя. Тэгээд тэрүүгээрээ цөмөөрөө санал хураалгая.

Ер нь тэгээд ингэж байгаа шүү дээ Ж.Бат-Эрдэнэ дарга аа. Энэ угаасаа тэр олон улсынхаа конвенцод тавьж байгаа шаардлагын дагуу хуучин байсныгаа задалж бичээд л нэмж оруулчихлаа гэж хараад байгаа шүү дээ. Түүнээс нэмж ерөөсөө нэр юу оруулаагүй. Найруулаад л 4 байсныг нь задлаад л 6 болгоод оруулж байгаа.

Тэгэхээр ганцхан тэр үг, нэр томъёоны л нэг асуудал байгаа юм байна.

Би дахиад уншчихъя.

Төслийн 12 дугаар зүйлийн 12.1.2, 12.1.3, 12.1.4 дэх заалтыг 12.1.2, 12.1.3, 12.1.4, 12.1.5, 12.1.6 дахь заалт болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.1.2.Монгол Улсад иргэний агаарын хөлгийг бүртгэх, нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ олгох, агаарын хөлөг, бүтээгдэхүүн, эд ангийг.

Тийм байна. Энэ дээр үү? Агаарын хөлөг, эд ангийг гэрчилгээжүүлэх, нислэгт тэнцэх чадварын удирдамжийг гаргах, техник үйлчилгээний ерөнхий шаардлагыг тогтоох.

12.1.3.хувь хүнд мэргэжлийн үнэмлэх, зэрэглэл, эрүүл мэндийн гэрчилгээ олгох;

12.1.4.ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагаа эрхлэх;

12.1.5.иргэний нисэхийн дүрмийг албадан хэрэгжүүлэх, дүрмийн шаардлагаас чөлөөлөх;

12.1.6.осол, зөрчлийг мэдээлэх;”

Л.Халтар сайд. Ажлын хэсгийн 1 номерыг нэе. Ажлын хэсгийн 2 номерыг нээгээдэхье.

**Л.Халтар:** Та бүхэнд өдрийн мэнд хүргэе.

Энд ойлголтын жоохон зөрүү яваад, сая тайлбар нь жоохон тийм хөндлөн болчих шиг боллоо.

Гурван том юм байгаа юм. Үүнийг та бүхэн, гишүүд маань нэг анхаараад өгөөч ээ гэж.

Нэгдүгээрт, гэрчилгээ олгоход агаарын хөлөг. Агаарын хөлөг яах вэ гэхээр бидний хар ярианы хэллэгээр “онгоц”. Онгоцны түүнтэй хамаатай бүтээгдэхүүн юу вэ. “Бүтээгдэхүүн” гэдэг бол өөрөө жишээлбэл “сэнс”. Сэнс гэдэг бол өөрөө магадгүй хэдэн зуун эд ангиас бүрдэж болно. Сэнсийг “бүтээгдэхүүн”. Сэнсийг бүрдүүлж байгаа дотор хэсгүүд байж болно. Жижигхэн доголдол гарлаа. Тэнд бид яах вэ гэхээр эд анги солино гэсэн үг.

Тэгэхээр агаарын хөлөг, агаарын хөлгийн нөгөө сэнс, том мотор гэвэл өөрөө “бүтээгдэхүүн”. Моторыг бүрдүүлж байгаа хэсгүүдийн жижиг хэсгүүд “эд анги”. Ийм байдлаар явж байгаа юм шүү.

Үүнийг сая тайлбар дээрээ жоохон юу яачих шиг боллоо.

Тийм учраас “бүтээгдэхүүн” гэдэг үгийг бид хасаж болохгүй нь ээ. Өөрөөр хэлбэл “агаарын хөлөг” гэхээд шууд “эд анги” гэвэл бүр жижигсээд явчих гэж байна.

Моторыг тэр чигээр нь солино гэвэл бүтээгдэхүүнийг гэрчилгээжүүлэх асуудал буюу моторыг хийж байгаа газар, түүний засварыг гэрчилгээжүүлэх.

“Бүрэлдэхүүн хэсэг” гэдэг чинь өөрөө. Үгүй ээ үгүй. Биш л дээ. Би мотор ярьж байна шүү дээ.

Моторыг бүтээгдэхүүн гэнэ. Тэр үйлдвэрлэж байгаа аль нэг үйлдвэрлэл дээр гарч байгаа олон эд ангиас бүрдсэн бүтээгдэхүүн.

Тэрийг бүрдүүлж байгаа юм нь өөрөө “эд ангиуд”. Утас өөрөө бүтээгдэхүүн. Утсан дотор байгаа жижиг зүйлүүд, микро элементүүд өөрөө эд анги. Тийм.

**Ц.Цэрэнпунцаг:** Л.Халтар сайд аа, таны сая ярьсныг ингэж ойлголоо.

Гурван нэр томъёо энд байх ёстойгоос “агаарын хөлөг” нь байна, “эд анги” гэдэг нь байна, “бүтээгдэхүүн” гэдгийг нь бид аваад хаячихвал тэр нь огт байхгүй болчих гээд байна л гэж байна. Тийм үү?

Яах вэ үүнийгээ протокол дээр тэмдэглэх тэгэх үү? Тэгээд ойлголтыг нэг жигдлэх.

Тэгье. Ер нь тийм юм бол Л.Халтар сайд түрүүхэн намайг уншихаас өмнө уг нь хэлчихсэн бол хоёр ажил болохгүй байсан юм. Тийм байна. Тийм байна.

Дахиад уншчихья. Би дахиад бүтнээр нь уншлаа.

Одоо бид хоёр дахь санал дээрээ яваа шүү дээ.

Төслийн 12 дугаар зүйлийн 12.1.2, 12.1.3, 12.1.4 дэх заалтыг 12.1.2, 12.1.3,

12.1.4, 12.1.5, 12.1.6 дахь заалт болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.1.2.Монгол Улсад иргэний агаарын хөлгийг бүртгэх, нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ олгох, агаарын хөлөг, бүтээгдэхүүн, эд ангийг гэрчилгээжүүлэх, нислэгт тэнцэх чадварын удирдамж гаргах, техник үйлчилгээний ерөнхий шаардлагыг тогтоох;

12.1.3.хувь хүнд мэргэжлийн үнэмлэх, зэрэглэл, эрүүл мэндийн гэрчилгээ олгох;

12.1.4.ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагаа эрхлэх;

12.1.5.иргэний нисэхийн дүрмийг албадан хэрэгжүүлэх, дүрмийн шаардлагаас чөлөөлөх;

12.1.6.осол, зөрчлийг мэдээлэх;”

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүд ээ, анхааралтай байгаарай. Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 70.0 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.3 дахь заалтын дагуу хураалгах санал.

3.Төслийн 15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсгийн “14.1,” гэснийг хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 70.0 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.3-д заасны дагуу хураалгах санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “Иргэний нисэхийн тухай хуулийн 7.1.3-т” гэснийг “Иргэний нисэхийн тухай хуулийн 7.1.3-т заасны дагуу тогтоох бөгөөд уг асуудлаар батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас санал авсан байна” гэж, мөн зүйлийн “Иргэний нисэхийн тухай хуулийн 8.1.7-д” гэснийг “Иргэний нисэхийн тухай хуулийн 8.1.7-д заасны дагуу тогтооно” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 70.0 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар санал хураалт явуулж дууслаа. /алх цохив/

Одоо Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 9 дүгээр зүйлд Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага Засгийн газрын тохируулагч агентлаг байх зохицуулалт тусгагдсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийг үндэслэн боловсруулсан “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Та бүхэнд тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2020 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 07 дугаар дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-ийн Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд “Засгийн газрын тохируулагч агентлаг” гэсэн хэсэгт “10.Иргэний нисэхийн ерөнхий газар” гэж нэмсүгэй.

2.“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2020 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 07 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-ийн Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг” гэсэн хэсгийн “20.Иргэний нисэхийн ерөнхий газар” гэснийг хассугай.

3.“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2020 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 07 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-ийн “Засгийн газрын хэрэгжүүлэгч

агентлаг” гэсэн хэсгийн 21, 22, 23, 24, 25, 26, 27, 28, 29 гэсэн дугаарыг “20, 21, 22, 23, 24, 25, 26, 27, 28” гэж тус тус өөрчилсүгэй.

4.Иргэний нисэхийн ерөнхий газрын орон тооны дээд хязгаарыг хууль тогтоомжид нийцүүлэн батлахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.

5.Энэ тогтоолыг Иргэний нисэхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Тогтоолын төслийг Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт батлах шаардлагатай байгаа тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.22 дахь хэсгийг үндэслэн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулья гэсэн горимын санал гаргаж байна.

Горимын саналаар санал хураалт явуулья. Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 70.0 хувь нь дэмжиж, горимын санал дэмжигдлээ.

Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ уншиж танилцуулна.

Дараагийн асуудалдаа орёе.



**Гурав.Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд**  
*/Засгийн газар 2023.01.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/*

Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэллээ.

Төслийг байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн ажлын хэсгийн ахлагч Ж.Бат-Эрдэнэ танилцуулна.

Ж.Бат-Эрдэнэ гишүүний микрофоныг нээе.

**Ж.Бат-Эрдэнэ:** Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдөр хуралдаж хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Эцсийн хэлэлцүүлэг техникийн шинжтэй хоёр саналыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь хэсэгт заасныг үндэслэн санал хурааж шийдвэрлэх нь зүйтэй гэж үзсэн тул саналын томьёоллыг Та бүхэнд хүргүүллээ.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх гаргасан саналын томьёоллыг нэгдсэн хуралдаанаар

дэмжсэн саналуудыг өргөн мэдүүлсэн төсөлд шигтгэн бэлтгэсэн эцсийн хэлэлцүүлгийг төсөл болон эцсийн хэлэлцүүлэгт хураалгах саналын томьёоллыг хэлэлцэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Ц.Цэрэнпунцаг:** Ж.Бат-Эрдэнэ гишүүнд баярлалаа.

Ажлын хэсгийг танилцуулъя. Л.Халтар Зам, тээврийн хөгжлийн дэд сайд, С.Батболд Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Д.Жавхлан Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэлтсийн дарга, С.Мяндасмаа Зам, тээврийн хөгжлийн яамны Хуулийн хэлтсийн дарга, Н.Наранчимэг Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын шинжээч.

Ажлын хэсгийн танилцуулгаас асуух асуулттай Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү? Х.Ганхуяг гишүүн. Х.Ганхуяг гишүүн асуултаа асууя.

**Х.Ганхуяг:** Л.Халтар сайдаас асуух гэсэн юм.

Төмөр замын зөвлөлийн дарга гэж явдаг байх аа. Тийм ээ. Дэд сайд нар. Үгүй юу? Тэгвэл яамны мэргэжилтнүүдээс нь давхар асууя.

Манайх чинь ингээд Оросын Холбооны Улстай транзит тээврийн нэлээн өндөр хөнгөлөлттэй гэрээ хийсэн байсан харагддаг. Сая шинэчлээд

хөнгөлөлтийг нь нэмчихсэн байгаа харагдсан.

Тэгээд энэ яагаад ганцхан талдаа тэр хөнгөлөлт нь яваад байдаг юм? Манайх Оросын Холбооны Улсаар транзит тээвэр хийлгэхээр тодорхой хэмжээний хөнгөлөлт байдаг эсэх? Байдаггүй юм бол яахаараа манай улсаар тээвэр хийхээрээ хөнгөлөлттэй байдаг юм?

Тэр хөнгөлөлтийнх нь төлөө манай тал Оросын Холбооны Улстай холбоотой, эсвэл Оросын тэр төмөр замаас тодорхой хэмжээний хөнгөлөлт, урамшуулал тэр авдаг юм байдаг уу, үгүй юу? Үүнийг л нэг тодруулчихмаар санагдаад байгаа юм.

Тэгээд хоёрдугаарт, манай хуулиар ер нь манай Улаанбаатар төмөр зам ч байдаг юм уу, ер нь олон улсын стандарт руу шилжих тийм шилжилт хийгдэх үү, үгүй юу?

Манайхаас бусад бүх орон чинь цахилгаан л болчихоод байгаа шүү дээ. Төмөр замын тээвэр. Тийм ээ. Манайх чинь нөгөө дизель хөдөлгүүртэй хэвээрээ л яваад байдаг.

Тэгээд энэ л хоёр асуултад хариу авчихмаар байна. Баярлалаа.

**Ц.Цэрэнпунцаг:** Ажлын хэсгийн 2 номер. Тийм. Таны урд байгаа 2 номер мөн. 2 номерын микрофоныг нээе. Л.Халтар сайд хариулъя.

**Л.Халтар:** Х.Ганхуяг гишүүний асуултад хариулъя.

Төгсгөлөөс нь эхлээд явчихъя. Цахилгаанжуулалтын асуудал.

Ер нь 2004, 2005 онд цахилгаанжуулах ТЭЗҮ төмөр замын

хэмжээнд боловсруулсан юм. Тэгээд замын хэмжээнд хийхэд 2.8-аас 3 тэрбум долларын хөрөнгө оруулалт шаардлагатай гэж.

Өөрөөр хэлбэл бүх замын дагуу “контактын сет”, тэгээд бүх зүтгүүрээ солино. Электровозууд орж ирнэ. Ингээд үзсэн. 3 тэрбум доллар. Тэгээд М.Фрадков гэж хүн Оросын Холбооны Ерөнхий сайд Монгол Улсад айлчлах үед энэ асуудлыг зүтгүүрийн депо дээр урьж аваачиж танилцуулаад.

Тэгээд ер нь яах вэ, ТЭЗҮ-гээ боловсруулчих, тэгээд хоёр талыг нь Засгийн газар үзье ээ гэж. Ингээд дараа нь Оросынхонд хүргүүлсэн.

Манай талаас тухайн үедээ Эрчим хүчний яамнаас ямар асуудал манайд тавьсан гэхээр цахилгаанжуулж болно. Яаж ийж байгаад зээл авъя. Ганцхан цахилгааны эх үүсвэр Монгол Улсын хэмжээнд Улаанбаатар төмөр замыг цахилгаанжуулсан нөхцөлд яагаад ч хангаж дийлэхгүй. Дахиад гаднаас цахилгааны эх үүсвэрийг авах асуудал орж ирэх нь ээ гэдэг байдал дээр ярьж байгаад ингээд түр хойшилсон.

Одоо бол яах вэ, дизелийн хувьд гайгүй.

Бид дизель гэхээсээ илүү суурь бүтцийн их засвар, шинэчлэлийн асуудлыг ярих шаардлагатай гээд эхнээсээ яриад овоо юм хийх гээд төлөвлөөд явж байгаа.

Хоёрдугаарт нь, тарифын хувьд ярьж байна.

Сая тарифыг хөнгөлөлтийг нь нэмээгүй. Харин Оросын Холбооноос Улсаас манайхаар дамжаад Хятад руу явдаг ачааны хэмжээ их.



Хятадаас манайхаар дамжаад Орос руу явдаг ачааны хэмжээ энэ чинь 2017, 2018 он хүртэл их зөрүүтэй байсан юм.

Тэгээд тэрийг одоо адил хэмжээнд авчрахын тулд бид Хятадаас Монголоор дамжаад Орос руу явдаг ачаан дээр 15 хувийн хөнгөлөлт илүү өгчихсөн байсан.

Одоо ингээд ачааны хэмжээ ерөнхийдөө баланс барьчихсан учраас сая Оросуудтай ярьж байгаад Хятадаас Орос руу явах ачааны чиглэлд 15 хувийн маршрутын хөнгөлөлтийг хүчингүй болгочихсон.

Одоо цаашдаа бид транзит тээврийн тарифыг үе шаттайгаар хөнгөлөлтүүдээ хасья гэдэг саналыг Оросын талд манай сайд сая явахдаа тавьсан. Үүнийг цаашдаа бид тавиад ажил хэрэг болгоод явах ёстой гэж.

**Ц.Цэрэнпунцаг:** Х.Ганхуяг гишүүн нэмж асууя.

**Х.Ганхуяг:** Тэгээд миний сонирхоод байгаа юм нь дээр хариулт авсангүй л дээ.

Яагаад дотоодын аж ахуйн нэгжүүдийн тэр тээврийн хөлс төлж байгаа мөнгөөр бид Оросын Холбооны Улс болон бусад орнуудын тээврийг санхүүжүүлэх ёстой юм бэ гэдэг л асуултыг би асуугаад байгаа байхгүй юу.

Вагон тавиулах гээд. Одоо юу гэдэг юм, манай дотоодын аж ахуйн нэгжүүд экспорт хийх гэхээр вагон нь ч олддоггүй. Нэг бол тэнд нэг авлигачин нөхөр мөнгө авч байж тэр вагоныг нь тавьж өгдөг.

Тэгээд сая дахиад л бүх тээврийн хөлсөө нэмчихсэн байсан шүү дээ. Тэгсэн мөртлөө л нөгөө хоёр транзитынхаа үнэ, хөлсийг нь хөнгөлнө гээд л яваад байх

юм. Энэ чинь ерөөсөө болохгүй байгаад байна шүү дээ. Үүнийг л би асуугаад байгаа байхгүй юу.

Энэ чинь манай цорын ганц экспорт, импортын суваг байгаа шүү дээ. Тэгсэн мөртлөө бид экспортоо ч олигтой ч чаддаггүй, импортоо ч олигтой ч чаддаггүй. Тэгснээ бусад орны транзит тээвэр дээр хөнгөлөлт үзүүлээд яваад байдаг юм.

Үндсэндээ юу гэсэн үг юм. Энэ чинь Монголын дотоод аж ахуйн нэгжүүдийн нуруун дээр тэр транзит тээврийг хийгээд байна л гэсэн үг шүү дээ.

**Ц.Цэрэнпунцаг:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Ингээд хуулийн төслийн анхны хэлэлцүүлгээр санал хурааж шийдвэрлэсэн боловч ажлын хэсгийн зүгээс дахин санал хураалгахаар бэлтгэсэн саналуудаар санал хураалт явуулж эхэлье.

Эдгээр саналууд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-д заасны дагуу хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос дээш хувийн санал авч байж дэмжигдэнэ.

Ингээд санал хураалт явуулъя. Та бүхэндээ саналын томъёоллыг уншиж танилцуулъя.

Нэг.Төмөр замын тээврийн тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

1.Төслийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсгийн “суурь бүтэцтэй огтлолцох” гэснийг “суурь бүтэцтэй ижил бус түвшинд огтлолцох” гэж өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг.  
Санал хураалт. /алх цохив/

Гуравны хоёроор босох ёстой шүү.  
Тийм. Бүгд дэмжихгүй бол.

Ингээд гишүүдийн 70.0 хувь нь  
дэмжиж, санал дэмжигдлээ.

Хоёр.Улсын тэмдэгтийн  
хураамжийн тухай хуульд нэмэлт,  
өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн  
талаарх зарчмын зөрүүтэй саналын  
томьёолол.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн  
“29.1.12” гэснийг “29.1.13” гэж өөрчлөх.

Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 70.0 хувь нь дэмжиж,  
санал дэмжигдлээ.

2.Төслийн 3 дугаар зүйлийг доор  
дурдсанаар өөрчлөн найруулах:

**“3 дугаар зүйл.**Улсын тэмдэгтийн  
хураамжийн тухай хуулийн 6 дугаар  
зүйлийн 6.2 дахь хэсгийн “29.1.1, 29.1.2,  
29.1.3,” гэснийг хассугай.”

Санал гаргасан Ажлын хэсэг.  
Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 70.0 хувь нь дэмжиж,  
санал дэмжигдлээ.

Санал хураалт явуулж дууслаа.  
/алх цохив/

Төмөр замын тээврийн тухай  
хуулийн шинэчилсэн найруулгын  
төслийн 10 дугаар зүйлд төмөр замын  
тээврийн асуудал хариуцсан төрийн  
захиргааны байгууллага Засгийн газрын  
хэрэгжүүлэгч агентлаг байх зохицуулалт  
тусгагдсантай холбогдуулан Монгол  
Улсын Их Хурлын чуулганы хуралдааны

дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийг  
үндэслэн боловсруулсан “Тогтоолд  
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын  
Их Хурлын тогтоолын төслийн анхны  
хэлэлцүүлгийг явуулъя.

Та бүхэнд тогтоолын төслийг  
уншиж танилцуулъя.

Тогтоолын хавсралтад нэмэлт,  
өөрчлөлт оруулах тухай.

Монгол Улсын Их Хурлын тухай  
хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг,  
Монгол Улсын Засгийн газрын тухай  
хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт  
заасныг үндэслэн Монгол Улсын Их  
Хурлаас ТОГТООХ нь:

1.“Төрийн захиргааны  
байгууллагын тогтолцоо, бүтцийн  
ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах  
тухай” Монгол Улсын Их Хурлын 2020  
оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 07  
дугаар тогтоолын хавсралтаар баталсан  
“Төрийн захиргааны байгууллагын  
тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-  
ийн Зам, тээврийн хөгжлийн сайдын  
эрхлэх асуудлын хүрээний “Засгийн  
газрын хэрэгжүүлэгч агентлаг” гэсэн  
хэсэгт “20.Төмөр замын газар” гэж  
нэмсүгэй.

2.“Төрийн захиргааны  
байгууллагын тогтолцоо, бүтцийн  
ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах  
тухай” Монгол Улсын Их Хурлын 2020  
оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 07  
дугаар тогтоолын хавсралтаар баталсан  
“Төрийн захиргааны байгууллагын  
тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-  
ийн “Засгийн газрын хэрэгжүүлэгч  
агентлаг” гэсэн хэсгийн “20, 21, 22, 23,  
24, 25, 26, 27, 28” гэсэн дугаарыг “21, 22,  
23, 24, 25, 26, 27, 28, 29” гэж  
өөрчилсүгэй.

3.Төмөр замын газрын орон тооны дээд хязгаарыг холбогдох хууль тогтоомжид батлахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-г даалгасугай.

4.Энэ тогтоолыг Төмөр замын тээврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Тогтоолын төслийг Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт батлах шаардлагатай байгаа тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.22 дахь хэсгийг үндэслэн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулъя гэсэн горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. Гишүүд ээ, анхааралтай байгаарай. Санал хураалт. /алх цохив/

Саяын санал хураалт дээр Х.Ганхуяг гишүүний санал хураагдсангүй. Та горимын санал гаргах уу?

**Х.Ганхуяг:** Миний төхөөрөмж ажилласангүй тул санал хураалтыг дахиж явуулж өгнө үү.

**Ц.Цэрэнпунцаг:** Саяын санал хураалт дээр Х.Ганхуяг гишүүний төхөөрөмж ажиллаагүй тул саяын хураасан саналыг хүчингүй болгоё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 70.0 хувь нь дэмжиж, саяын санал хураалт хүчингүй болсон тул саналыг дахин явуулъя. Санал хураалтыг дахин явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 70.0 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлэг, тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ уншиж танилцуулна.

Дараагийн асуудалдаа орёе. Ажлын хэсгийнхэнд баярлалаа. Та бүхэн явж болно.

---

**Дөрөв.Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд**  
*/Засгийн газар 2023.06.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/*

---

Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Хуулийн санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, Монгол

Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар танилцуулна.

Ч.Хүрэлбаатар сайдын микрофоныг нээе. Ажлын хэсгийг оруулъя.

**Ч.Хүрэлбаатар:** Байнгын хорооны дарга, Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулиар Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна гэж тусгасан.

Төрөөс Үндсэн хуульд нийцүүлэн Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогыг батлахдаа эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих бодлогыг тодорхойлж, энэ хүрээнд гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх асуудлыг тусгасан.

Монгол Улсын Засгийн газраас бодлогын баримт бичигт тусгасан хөрөнгө оруулалт хотын орчныг сайжруулах, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих бодлогын хүрээнд Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан өргөн бариад байна.

Хууль санаачлагчийн зүгээс гадаадын хөрөнгө оруулалтыг татах бодлогыг тодорхойлохын тулд өнөөгийн тулгамдаж байгаа нөхцөл байдлыг судалсан.

Монгол Улсад 1990-ээс 2023 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 41.1 тэрбум долларын гадаадын хөрөнгө оруулалт орж ирснээс 73.0 хувь нь уул уурхайн олборлолт, 11 хувь нь худалдаа, үйлчилгээний салбарт хийгдсэн бол бусад салбаруудад нийлээд 16 хувийг эзэлж байгаа нь гадаадын хөрөнгө оруулалт төрөлжихгүй, зөвхөн нэг салбарт харьцангуй ихээр төвлөрч байгааг харуулж байна.

Оюу Толгой төслийн уул уурхайн олборлолт, бүтээн байгуулалттай холбоотойгоор Монгол Улсад орж ирэх гадаадын шууд хөрөнгө оруулалт 2011 оноос эрс нэмэгдэж, сүүлийн 10 жилийн дунджаар гадаадын шууд хөрөнгө оруулалтын 42 хувийг Оюу Толгой компани дангаараа бүрдүүлж байна.

Гэсэн хэдий ч нийт орж ирж буй гадаадын хөрөнгө оруулалтын урсгал чамлахаар хэмжээнд байна.

Монгол Улсын хэмжээнд 2023 оны 1 дүгээр улирлын байдлаар хуулийн этгээдийн улсын бүртгэлд нийт 246.8 мянган аж ахуйн нэгж бүртгэлтэй байгаагаас гадаадын хөрөнгө оруулалттай 9350 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлд 1990-2023 онд нийт 14836 гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж бүртгэгдсэнээс 5486 аж ахуйн нэгж татан буугдсан байна.

Эдгээр аж ахуйн нэгжийн 33 хувь нь 2010-аас 2022 онд татан буугджээ.

Дээрх нөхцөл байдлыг дүгнэвэл гадаадын хөрөнгө оруулалт нь уул уурхайн салбарт илүүтэй хийгдэж байгаа нь Монгол Улсын эдийн засгийн төрөлжилт энэ хэмжээгээр хязгаарлагдмал, бусад салбарт гадаадын хөрөнгө оруулалт орж ажиллах нөхцөл, боломж хязгаарлагдмал байгааг илтгэж байна.

Хуулийн төслийг нийт 65 хоногийн хугацаанд иргэд, олон нийт, хөрөнгө оруулагч нарын дунд нээлттэй хэлэлцүүлж, санал авсан бөгөөд олон улсын байгууллага, гадаад улсын Элчин сайдын яамд, мэргэжлийн холбоод, бизнесийн зөвлөл, танхимууд, төрийн байгууллага, гадаад, дотоодын 120

байгууллагын 250 орчим төлөөллөөс 695 саналыг хүлээн авсан.

Хууль санаачлагчийн зүгээс олон нийтээс ирүүлсэн санал, хуулийн хэрэгжилтийн үр нөлөө болон практик шаардлагад нийцүүлж гадаадын хөрөнгө оруулалтыг шинээр татах, эдийн засгийг төрөлжүүлэх, суурийг тэлэх, хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах тогтолцоог бүрдүүлэх, хөрөнгө оруулагчдад үзүүлэх төрийн үйлчилгээг хялбаршуулах замаар хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлэх, хөрөнгө оруулалтыг хадгалах зорилгод нийцүүлэн хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөлд туссан зарчмын гол асуудлуудыг дурдъя.

**1.Хөрөнгө оруулалтыг төрөлжүүлэх, шинээр орж ирэх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилгоор гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, байгууллага байгуулахад шаарддаг 100 мянган ам.доллар, зарим салбар дахь гадаадын хөрөнгө оруулалт тавьсан хязгаарлалтыг байхгүй болголоо.**

Ингэснээр эдийн засгийг төрөлжүүлэх нөхцөл бүрдэх ба уул уурхайн салбарын хөрөнгө оруулагч нараас гадна бусад салбарт хөрөнгө оруулалтыг энэ хуулиар татах боломж бүрдэнэ гэж үзэж байна.

**2.Хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор Хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах зөвлөлийг байгуулж төрийн байгууллага, төрийн албан хаагчийн хууль бус үйлдэл, эс үйлдэхүйтэй холбоотой хөрөнгө оруулагчийг хохироосон аливаа гомдлыг шалган шийдвэрлэх зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан.**

Энэ зохицуулалт туссанаар хөрөнгө оруулагчид өөрсдийн үйл ажиллагаанд үүссэн хүндрэл, бэрхшээлийг цаг алдалгүй шийдүүлэх, цаашилбал гомдол нь даамжран шүүхийн болон арбитрын маргаан болж төрд болон хөрөнгө оруулагчдад хүндрэл үүсгэдэг байдлыг арилгана гэж үзэж байна.

**3.Түүнчлэн гадаадын хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалттай холбоотой гомдол, маргаан үүссэн тохиолдолд олон улсын арбитра хандах эрхийг нээлттэй болгож, хөрөнгө оруулагчийн хөрөнгийг хууль бусаар дайчлан хураахгүй байх баталгааг төрөөс олгох тухай зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан.**

Хөрөнгө оруулагчийн хөрөнгийг хамгаалах баталгааны зохицуулалтыг хуульд тусгаснаар Монгол Улсад хөрөнгө оруулалт хийх итгэлийг сэргээнэ гэж үзэж байна.

**4.Хөрөнгө оруулагчийн үйл ажиллагаанд төрөөс тухайн жилд төлөвлөгөөт хяналт шалгалтын тоог хуулиар тогтоон, хязгаарлаж хэрэгжүүлэхээр тусгалаа.**

Энэ нь хөрөнгө оруулалт, бизнес эрхлэлтийг дэмжих, төрийн хүнд суртлыг бууруулах, бизнесийн үйл ажиллагаанд учруулдаг шаардлагагүй дарамтыг бууруулах томоохон хөшүүрэг болно гэж харж байна.

**5.Хөрөнгө оруулалтын чиглэлээр төрийн байгууллагуудын хүлээх үүргийг ойлгомжтой тодорхойлж тусгалаа.**

Эрх бүхий байгууллагын шийдвэрээр хөрөнгө оруулагчдад төрөөс нөхөн төлбөр олгохоор шийдэгдсэн тохиолдолд тухайн хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх ашгийг хохироосон

шийдвэр гаргасан эрх бүхий албан тушаалтнаар төрд учирсан хохирлыг буцаан төлүүлэх, хариуцлага тооцох тухай зохицуулалтыг тусгалаа.

Энэхүү зохицуулалт нь аливаа албан тушаалтан нь хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх ашгийг хувийн үзэмж, ашиг сонирхлын үүднээс ялгамжтай байдлаар шийдвэр гаргаж хохироодог байдлыг бууруулахад хувь нэмрээ үзүүлнэ гэж үзэж байна.

**6.Хөрөнгө оруулагч нарт үзүүлэх төрийн үйлчилгээг хялбаршуулж, нэг цонхны зарчмаар хөрөнгө оруулагчдад үйлчилгээ үзүүлэхээр тусгалаа.**

Өөрөөр хэлбэл хөрөнгө оруулагчдад үйлчилгээ үзүүлэх төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг цахимжуулах замаар хөрөнгө оруулагчид нэгдсэн нэг сувгаар төрийн дэмжлэг, үйлчилгээг үзүүлэх давуу тал бий болно гэж үзэж байна.

**7.Хөрөнгө оруулагч нарт эргэлзээ үүсгэж байсан Хөрөнгө оруулалтын тухай хуулийн зарим зүйл, заалтыг ойлгомжтой болгож хуулийн давхардлыг арилгалаа.**

Тухайлбал, татварын хөнгөлөлт, чөлөөлөлттэй холбоотой зохицуулалт нь татварын хуульд заагдаагүй тохиолдолд хэрэгждэггүй байсан.

Иймд хөрөнгө оруулагч нарт эргэлзээ үүссэн дээрх зохицуулалтыг энэхүү хуулийн төслөөс бүрмөсөн хасаж, аливаа татварын дэмжлэгийг зөвхөн татварын хуулиар зохицуулж байхаар төсөлд тусгалаа.

**8.Хөрөнгө оруулалтын тухай хуулийн дагуу үзүүлэх татварын хувь, хэмжээг тогтворжуулах асуудлыг тодорхой ойлгомжтой болгосон.**

Тухайлбал, тогтворжуулах гэрчилгээ олгох асуудлыг хялбаршуулж шаардлага хангасан аж ахуйн нэгжийн хүсэлтэд үндэслэн цахимаар шийдвэрлэдэг байх зохицуулалтыг хуулийн төсөлд тусгалаа.

Хуулийн төслийг Байнгын хороогоор хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Ц.Цэрэнпунцаг:** Ч.Хүрэлбаатар гишүүнд баярлалаа.

Ингээд ажлын хэсгийг танилцуулъя.

Чимэдийн Хүрэлбаатар Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Гантөмөрийн Түвдэндорж Эдийн засаг, хөгжлийн дэд сайд, Бат-Ирээдүйн Анар Эдийн эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын газрын дарга, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Шийрэвдамбын Маргад Эдийн засаг, хөгжлийн яамны Төслийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Саруулын Пүрэвсүрэн Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын зөвлөх, Эрдэнэбатын Цацрал Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын зөвлөх.

Хууль санаачлагчийн илтгэл болон төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгнө үү?

Д.Батлут гишүүнээр тасаллаа.  
О.Цогтгэрэл гишүүн та асуулт асуух уу?  
Х.Ганхуяг гишүүнээр тасаллаа.



Ч.Ундрам гишүүний микрофоныг нээе. Асуултаа асууя.

**Ч.Ундрам:** Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэж байна. Тэгээд ерөнхийдөө дэмжиж байгаа юм. Тэгээд хэд хэдэн асуулт байна.

Нэгдүгээрт, хөрөнгө оруулалтын урамшуулал гэж 4 дүгээр бүлэг байна л даа.

Тэгээд хөрөнгө оруулагчид төрөөс татварын хувь, хэмжээг тогтворжуулах урамшуулал үзүүлж болно гэсэн байна. Энэ яг ямар учиртай, хэрхэн олгогдох юм бол?

Тэгээд салбарыг нь зааж өгөх болов уу? Жишээлбэл, манай улсад орж ирж байгаа хөрөнгө оруулалтын дийлэнх хувь нь уул уурхайн салбарт байна гээд. Түрүүн 72 хувь нь гэж ярьж байна л даа.

Тэгэхээр бусад уул уурхайн бус, ялангуяа технологи, “ноу хау” гэсэн тэр салбар луу нь илүү урамшуулал нь ордог байдлаар хуульчилж өгч болох уу? Эсвэл энэ урамшууллаа дагаад журам гараад явах юм уу гэсэн асуулт байна.

Татварын бус урамшуулал дотор бас хэд хэдэн асуулт байна л даа. Энд нэгдүгээрт гадаад ажилтныг ажлын байрны төлбөрөөс хөнгөлөх чөлөөлөх гээд.

Тэгэхээр гаднаас ажилтан орж ирвэл одоо ерөөсөө ямар ч ажлын байрны төлбөр өмнө төлдөг байсан. Үүнийг төлөхгүй гэж ойлгож болох уу? Энэ бол мэргэжилтэй ажилтан болон, хар ажилтан гэдгээр нь ялгаж өгөх юм уу?

Мөн энэ дээр гадуур олон нийтэд мэтгэлцээн гараад байна л даа. Энэ

газрыг ашиглуулах асуудал гээд ороод ирсэн байна. Газрыг 15-аас 60 хүртэл жилээр ашиглуулах гэсэн энэ асуудал хуучин хууль дээр нь “**эзэмшүүлэх болон ашиглуулах**” гэж байж байгаад, одоо “**ашиглуулна**” гэдгээр зөвхөн орж ирсэн гэж ойлгож байгаа. Тийм үү? Үүнийг маш олон хүмүүс над руу хандаад бичээд байна.

Тэгээд Үндсэн хуулийг харах юм бол Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлд “газрыг ашиглуулна” л гэж, “гадаадын иргэнд ашиглуулж болно” л гэж заасны дагуу энд “эзэмшүүлэх”-ийг нь хасаад “ашиглуулна” гэж орж ирсэн байна гэж ойлгож байгаа. Энэ зөв биз дээ?

Бас нэг асуулт нь, хууль хүчний байгууллагууд гадаадын хөрөнгө оруулагчийг дээрэмдчихдэг асуудал манай улсад маш олон болж байсан.

Тэгээд Засгийн газраас, ялангуяа Х.Нямбаатар сайд нэг ажлын хэсэг гаргаад энэ дээр ажиллаж байгаа гэсэн. Тэр ямар шатанд явж байгаа вэ?

Өмнө нь Английн Ерөнхий сайд байсан хүний дүүг хүртэл дээрэмдчихсэн асуудал. Тэгээд одоо энэ “**Жапан таун**”, “**Суруга Монгол**”-ын захирлыг дээрэмдсэн, газрыг нь авчихсан асуудал гээд л маш том том хэргүүдийг бид яаралтай шийдэхгүй бол дараа дараагийн хөрөнгө оруулагчид тэрийг хүлээгээд хараад сууж байгаа.

Цаашид энэ хуулиар ийм зөвлөл байгуулагдаад гомдол, саналыг нь хүлээж аваад хурдан шийднэ, арбитраар шийддэг болно гээд маш дэвшилттэй юмнууд орсон байна л даа.

Гэхдээ өмнө нь гарсан асуудлыг бид яаралтай шийдэхгүй бол тэр хүмүүс чинь энэ асуудлууд яаж шийдэгдэх вэ

гэдгийг харж байж л хөрөнгө оруулах эсэхээ бодно шүү дээ. Тийм. Баярлалаа.

**Ц.Цэрэнпунцаг:** Ч.Хүрэлбаатар сайд хариулья.

**Ч.Хүрэлбаатар:** Ч.Ундрам гишүүний асуултад хариулья.

Хуучин Хөрөнгө оруулалтын тухай хуульд татварын заалтууд оруулаад өгчихсөн юм.

Тэгэхээр татварын байцаагч нар яадаг вэ гэвэл зөвхөн татварын хуулиа л үздэг. Өөр ямар ч хуулийг баримталдаггүй.

Тийм учраас нөгөө хоёр хуулийн хооронд зөрчилтэй байгаад байсан учраас татвартай холбоотой бүх асуудлыг бүгдийг нь татварын хуулиар зохицуулна гээд хөрөнгө оруулалтын заалтад байсан бүх заалтыг нь аваад хаячихсан байгаа.

Харин тэр хөрөнгө оруулагчид үзүүлэх урамшуулал гэдэг нэгдүгээрт нь татварынх нь орчныг тогтворжуулах тэр тогтворжуулалтын гэрчилгээ байгаа. Энэ нь одоогийн хуульдаа байгаа заалт. Тэгэхээр энэ нь хэвээрээ.

Дээр нь татварын бус урамшуулал гэсэн ийм зүйл байгаа гэдгийг хэлье. Тэр нь хууль дээр өмнө нь олгогдож байсан тэр урамшууллууд нь хэвээрээ явна гэсэн үг.

Дараагийн асуудал, энэ газрын тухай асуудал байгаа юм. Яах вэ, зарим нэг хүмүүсүүд одоо тийм буруу ташаа мэдээллийг гаргаж байгаа. Яагаад вэ гэхээр одоо хүчин төгөлдөр байгаа хуулиараа газрыг ерөөсөө 60 жил эзэмшүүлэх, ашиглуулах, нэмэх нь 40 жилээр сунгаж болно гээд одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Газрын тухай

хуулийн 12.1.1 гэсэн заалт дээр байгаа юм.

Тэгэхээр Үндсэн хууль дээр гадаадын аж ахуйн нэгжүүдэд газрыг эзэмшүүлж болохгүй гээд заачихсан байгаа учраас бид энэ оруулж ирсэн хууль дээр тэр “эзэмшүүлэх” гэдэг үгийг нь аваад хаячихсан гэж ойлгож болно.

Тэгэхээр ерөөсөө өмнө нь байсан зүйлээс Үндсэн хуультай зөрчилдөж байгаа зүйлээ бид аваад хаячихсан гэж та бүгд ойлгож болно. Үүнийг зарим хүмүүс мэдэхгүй биш мэдэж байгаа учраас санаатай мушгиж байгаа гэдгийг би энд онцолж хэлмээр байна.

Ажлын байрны төлбөртэй холбоотой одоо мөрдөгдөж явж байгаа хуулийн зохицуулалт яг хэвээрээ.

Энэ хуулиар янз бүрийн зүйлийг нэмж хөндөөгүй гэдгийг хэлье.

Дөрөв дэх асуулт бол энэ хөрөнгө оруулагч нарын гомдол. Энэ дээр Засгийн газар хоёр янзаар асуудалд хандаж байгаа.

Нэгдүгээрт нь, Х.Нямбаатар сайд дээр яг энэ гомдлыг нь аваад, хуулийнх нь хэрэгжилттэй холбоотой хууль хүчнийхний холбогдож хууль зөрчиж байгаа зүйлүүдийг шийдвэрлэх ажлын хэсэг ажиллаж байгаа.

Үүнээс гадна одоо юу байдаг юм, прокурор дээр хүртэл яг энэ Ерөнхий прокурорын газар дээрээс энэ холбоотой асуудлаар тусгай ажлын хэсэг гаргаад ажиллаж байгаа.

Засгийн газрын хувьд яаж байгаа вэ гэхээр нийтдээ хөрөнгө оруулагч нарын гомдлыг Засгийн газрын хуралдаанд улиралд нэг удаа хэлэлцдэг болчихсон.



Эхлээд эхний хуралд орж байхад бид нарт 32 аж ахуйн нэгж гомдол гаргасан байсан. Одоо дараагийнх нь хурал дээр 44 болоод нэмэгдчихсэн.

Тэгэхээр юу ч гэсэн бид төрийн албан хаагчдын гаргасан алдаа, ёс зүйгүй үйлдэл, бүгдийг нь оруулаад яриад засаад явж байгаа.

Тэгэхээр энэ удаагийн хууль дээр та яг сайн хэллээ. Хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах зөвлөл гээд байна.

Энэ зүгээр товчхондоо хэлэх юм бол нөгөө юутай адилхан. Татварын маргаан таслах зөвлөл гээд шүүх, арбитр эд нар луу шилжихийн өмнө эхлээд төр дээрээ энэ асуудлыг тал талаас нь яриад янз бүрийн маргаанд хүрэхгүйгээр наана нь шийдчихдэг зүйл байх юм бол түүн дээрээ ярьж гэж байгаа юм.

Тэгээд үндсэндээ шийдэж чадахааргүй бол тэгээд арбитр, шүүх рүү явах боломжийг нь нээж өгч байгаа юм.

Дээр нь энэ удаагийн энэ хуулиар арбитрыг сонгоод арбитрт хандах боломжийг нь нээж өгсөн зүйл байгаа.

Тэгэхээр тэр Хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах зөвлөл дээр бүх асуудлаа ярьж болно, арбитрт хандаж болно, шүүхэд хандаад явах бүх боломжийг нь нээж өгсөн байгаа гэдгийг хэлье. Баярлалаа.

**Ц.Цэрэнпунцаг:** Ч.Ундрам гишүүн хариулт хангалттай юу?

Т.Аубакир гишүүн асуултаа асууя. Т.Аубакир гишүүний микрофоныг нээ дээ.

**Т.Аубакир:** Баярлалаа. Хөрөнгө оруулалтын тухай хуулийг дэмжиж байгаа. Шинэчилсэн найруулгыг нь.

Манай улс бас энэ асуудлыг ярих болчихсон л доо. Яриад зогсохгүй үүнийг нэлээн шинэ түвшинд гаргах зайлшгүй нийгэм, эдийн засгийн шаардлага бий болчихоод байгаа юм.

Тийм учраас хуулийг үзэл хуримтлалын хүрээнд дэмжиж байгаа, хэлэлцэх нь зөв.

Энэ хуулиар үндсэндээ хэд хэдэн асуудлуудыг шийдэж байгаа юм л даа. Дэвшилттэй, гэрчилгээг нь баталгаажуулах. Энэ тогтворжуулах асуудлын зохицуулалтыг маш тодорхой болгож өгч байгаа юм.

Тэгээд харьяалагдах Эдийн засгийн яамандаа бас эзэнтэй болгож байгаа юм байна.

Дээрээс нь Элчин сайдын яамдыг жишээлбэл концептод нь тодорхой хэмжээний, зөвхөн геополитикийн асуудал биш, хөрөнгө оруулалтын тал дээр илүүтэй анхаарах ийм заалтууд орж ирсэн явдлыг дэмжиж байгаа.

Ганцхан асуулт байна. Гаднын хөрөнгө оруулагчид, мөнгөө бариад ирж байгаа хүмүүс намайг очиход хууль эрх зүйн орчин нь, миний оруулсан хөрөнгийг, миний эрх ашгийг хэр хамгаалах бол гэж хамгийн түрүүнд харна.

Татварыг мэдээжийн хэрэг захын бизнесмен татвар төлөх, тухайн улсынхаа татварын зохицуулалтыг захын бизнесмен ойлгоод, хайгаад судалчихдаг болчихсон.

Зарим улсад хөрөнгө оруулалтынхаа энэ санд байдаг юм уу,

хөрөнгө оруулах тэр орчныг илүү дэвшилтэд, илүү итгэл найдвартай болгохын тулд бизнесийн шүүх гээч юмыг байгуулаад явж байгаа туршлагауд дэлхий дээр маш их бий л дээ.

Ний нуугүй хэлэхэд манай Монгол Улсын шүүх, шүүх тогтолцоонд, энэ бизнесийн харилцаанд зөвхөн гаднын хөрөнгө оруулагчид төдийгүй дотоодын манай Монгол Улсын иргэд ч гэсэн шүүхэд эргэлздэг.

Би энэ шүүхийг яаж байгаа юм бол биш. Гэхдээ хамгийн түрүүнд надад хэрэв би мөнгөө бариад очиход ямар нэгэн маргаан үүсэхэд Монгол Улсын хуулиар Монгол Улсын шүүх намайг шүүх нь гэдэг дээр эргэлзээтэй л ханддаг.

Одоо сүүлийн үед буусан статистик харж байхад тодорхой хэмжээний хөрөнгө оруулалтууд буурсан. Тэдгээрийн хэдэн хувь нь энэ шүүхэд итгэх итгэлгүйдээ буцсан бол гэж харвал бас сонин тоо гарах байх л даа.

Тийм учраас Ч.Хүрэлбаатар сайд аа, энэ хууль дээр ер нь бизнесийн тусдаа шүүх болгох, түүн дээр яг зөвхөн тэр бизнесийн, одоо жишээлбэл сая та хэлж байна Засгийн газраар орсон маргаануудыг зөвхөн бизнесийн маргааныг шүүгээд сууж байх шүүхийг байгуулах тал дээр ер нь манай Засгийн газар яг яаж анхаарч байгаа вэ?

Хууль зүй, дотоод хэргийн сайд хэд хэдэн удаа хэлсэн. Гаднын хөрөнгө оруулагчдыг ирэхэд нь дээрэмддэг, луйварддаг хэрэг маш их боллоо гэж.

Одоо наад захын хөрш улсын жишээ байж байгаа юм. Сая бид ажлын хэсгээр Казахстан Улсад яваад ажиллаад ирсэн. Сан байгуулчихсан. Өөрсдөө бизнесийн шүүхтэй. Яг дэргэдээ арбитрын шүүхтэй.

Тухайн маргаан үүссэн талууд аль шүүхээр шүүлгэх сонголт нь хүртэл байж байгаа юм л даа.

Одоо манай яг энэ шүүхийн жишээлбэл ачаалал. Иргэний маргаан байдаг ч юм уу. Эрүү болчихдог. Сүүлдээ. Энэ маргаануудын очер дугаар ямар байгаа билээ гэх зэргийн механик.

Хөрөнгө оруулагчид гэдэг бол манай Монгол Улсад мөнгөө хийе, ажлын байр бий болгоё, баялаг бүтээе л гээд ирж байгаа улсууд. Хөрөнгө оруулалт ямар чухал билээ. Энэ эдийн засагт эзэлдэг байр суурь нь ямар чухал билээ гэдгийг захын хүн мэдэж байгаа. Гаднын хөрөнгө оруулалт гэдэг бол эдийн засагт зайлшгүй байр ёстой маш их хувийг эзэлдэг маш чухал салбар.

Тийм учраас Хөрөнгө оруулалтын тухай хууль дээр яриад явж байгаа явцад ер нь тэр шүүхийн талыг зөвхөн тэр бизнес, энэ хөрөнгө оруулалтын бизнесийг шүүгээд суух, тэр маргааныг түргэн шуурхай, найдвартай, итгэлтэй шүүх байгуулах талаар ер нь судалж үзсэн юм бий юу?

Гомдол, маргаан шийдвэрлэх тогтолцоог сайжруулна гээд энэ хуулийн үзэл баримтлал дээр явж байгаа юм. Гомдол, маргаан шийдвэрлэх тогтолцоог шийдвэрлэнэ гэж.

Хөрөнгө оруулагчдын тэр хүсэж байгаа харилцааг.../минут дуусав/

**Ц.Цэрэнпунцаг:** Ч.Хүрэлбаатар сайд хариулья.

**Ч.Хүрэлбаатар:** Хөрөнгө оруулалтын хуульд хуульд өөрчлөлт оруулахын тулд бид нийтдээ хоёр удаагийн том хэлэлцүүлэг зохион

байгуулсан. 695 санал. Үндсэндээ 700 санал ирсэн гэсэн үг.

Ирсэн саналуудын дийлэнх нь ерөөсөө бид хөрөнгө оруулалт хийлээ гэхэд бидний хууль ёсны эрх ашгийг яаж хамгаалах юм бэ гэдэг зүйл байгаа.

Тэгэхээр ерөнхийдөө сая Т.Аубакир гишүүний хэлсэн санал бол энэ хуулийн гол концепц нь л дээ.

Одоо гомдлыг яаж шийдвэрлэх вэ гэдэг асуудал байгаа. Ийм жишээ байгаа юм. Т.Аубакир гишүүн ээ.

Монголын шүүхээр хөрөнгө оруулагчийн гаргасан гомдол шийдвэрлэхэд дунджаар 6.2 жил зарцуулагдаж байна. Хамгийн олон жил зарцуулагдсан тохиолдол бол 16 жил.

Бүгдээрээ бодъё. Тийм ээ. Монгол Улсад өөрийнхөө харманаас, өөрийнхөө олж ирсэн мөнгөөрөө хөрөнгө оруулалт хийхээд түүнтэй холбоотой үүссэн маргааныг Монголын шүүхээр 16 жил яваад шийдүүлнэ гэдэг бол. Зөвхөн энэ тохиолдлын дараа хөрөнгө оруулагч нар бүгд үргэнэ шүү дээ. Тэгээд дунджаар 6 жил, 6.2 жил зарцуулагдаж байгаа.

Тийм учраас үүнийг бид сая бодож байгаад ерөөсөө нэгдүгээрт нь маргаан, нөгөө арбитр шүүх дээр очихоос өмнө эхлээд нэг Засгийн газар байгаа юм бол тэр орж ирэх зөвшөөрлийг нь өгсөн, хуулийнхаа дагуу татвар авч байгаа юм бол тэр Хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах зөвлөл гэдэг дээр энэ гомдлуудыг нь ярилцдаг байя.

Тэгээд түүн дээр шийдэгдэхгүй бол дараа нь арбитр, шүүх рүүгээ явдаг ийм боломжийг нь зааж өгсөн.

Бизнестэй холбоотой шүүхийн тухай заалтыг бид судалж үзсэн. Тэгээд

холбогдох хүмүүстэй нь нэлээд удаан ярилцсан юм. Эхлээд шүүхийн хуульдаа өөрчлөлт ороод энэ дээрээ шийдэгдэх юм байна.

Хэрвээ бид шүүх цэгцрэхийг хүлээгээд, бүх хуульдаа өөрчлөлт орохыг хүлээх зуур энэ хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах боломжийг бид алдаж байгаа.

Гэхдээ би Т.Аубакир гишүүний хэлж байгаа яг бизнесийн асуудлыг хэлэлцэж шийдвэрлэдэг тусгайлан шүүх байх нь Монгол Улсад хамгийн оновчтой зөв. Болж өгвөл тэнд ажилладаг шүүгч нарыг тийм олон улсаас сонгон шалгаруулалт хийж авч ирж урилгаар ажиллуулдаг, эсвэл онлайнаар ажиллуулдаг ийм болгож явж байж бид хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлнэ гэж үзэж байгаа юм.

Тэгэхээр одоо тэр нөхцөл бүрдээгүй байгаа юм чинь одоо байгаа хуульдаа бид максимум хэмжээгээр энэ хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх, хөрөнгө оруулагч нарын эрх ашгийг хамгаалах, маргаан үүсвэл тэрийг яаж шийдвэрлэх вэ гэдэг л заалтаа бодож байж энд оруулж ирж өгсөн байгаа.

**Ц.Цэрэнпунцаг:** Ж.Бат-Эрдэнэ гишүүн асуултаа асууя.

**Ж.Бат-Эрдэнэ:** Хөрөнгө оруулалтын тухай хууль орж ирлээ.

Эдийн засаг, хөгжлийн яам нэлээдгүй зүйлүүд хийж байгаа. Түүний гол авч хэлэлцүүлэх Монгол Улсын эдийн засагт нөлөө бүхий том хуулиудын нэг орж ирлээ гэж ойлгож байгаа.

Ер нь бид хөрөнгө оруулалтаа оруулж байж, дэлхий нийттэй хөл нийлүүлж байж хөгжинө шүү дээ. Тэр утгаараа хөрөнгө оруулалт нь маш чухал.

Тэгэхээр энд хоёр, гурван асуулт байгаад байгаа юм. Одоо хүн болгоны л асуугаад байгаа асуудал байна шүү дээ.

Ер нь бид хөрөнгө оруулалтын таатай нөхцөлийг бүрдүүлнэ ч гэдэг юм уу, хөнгөлөлт үзүүлнэ гээд.

Гадаадын хөрөнгө оруулагчид чинь хөнгөлөлттэй нөхцөл байхгүй байна гээд л орж ирэхгүй байгаад байгаа юм биш шүү дээ. Тийм үү. Шударга байх зарчмыг л бий болгооч ээ л гэсэн асуудлууд яригдаад байгаа шүү дээ. Хамгийн гол асуудал, ерөөсөө. Зоригтой орж ирэх, ажиллах боломж, нөхцөл бүрдэх. Энэ нөхцөл байдал нь бий болж байна уу, үгүй юу гэдэг талаасаа л харж байгаа болохоос биш хөнгөлөлт байхгүй байна гээд бид нарыг тойрч яваад байгаа юм биш шүү дээ. Тэгээд тэр утгаараа сая та нэлээдгүй хариулт өгчихлөө.

Ер нь орж ирэх нөхцөл бололцоог нь нээлттэй болгож өгнө. Татварын болоод бусад хөнгөлөлтүүд. Дээрээс нь хөрөнгө оруулахаас айж ичдэггүй болгох, хууль хяналтын хүрээнд байдаг боломж бололцоо нээгдэх юм шиг байна.

Энэ нэг зүйл жоохон хаягдчих шиг боллоо. Төрийн албан хаагчид дээр нөгөө зөвшөөрөл өгдөг энэ тэр хүнд суртлын чинь асуудлууд хэр байх вэ? Одоо яваад очингуут л дахиад өөдөөс нь нэг жоохон гар хараад байдаг иймэрхүү зүйлүүд.

Ер нь хөрөнгө оруулагч чинь нууц биш шүү дээ. Нөгөөдүүлийн чинь ярьдаг зүйл энэ шүү дээ. Юм хараад байдаг гэсэн нэг ийм зүйл л байгаад байгаа юм.

Тэгэхээр энэ дээр яг төрийн албан хаагчидтай холбоотой, тэр зөвшөөрөл өгдөг процедурын асуудал дээр нь дундуур нь орж ирээд наана цаана болоод

байдаг ийм зүйлүүд нь хэр их харагдаж байгаа юм, хэр хамгаалж байгаа вэ гэж.

Хоёрдугаарт, мэдээж хөрөнгө оруулалтын асуудал дээр дотоодын аж ахуйн нэгжүүдтэйгээ уялдаа нь ямаршуу байх юм, тэд нараас монопол том эрх өгч байна уу, үгүй юу гэдэг асуудлууд.

Дээрээс нь дотоодын аж ахуйн нэгжүүдээ хамгаалах асуудлууд. Тийм үү? Өөрөөр хэлбэл тэр бүтээгдэхүүн нь орж ирээд ингээд цохиод явчихдаг. Нөгөө дотоодын аж ахуйн нэгжүүдийн бүтээгдэхүүн нь унадаг ч байдаг юм уу, монопол зах зээлийг нь эзлэх ч байдаг юм уу. Энэ тал дээр ямархуу зохицуулалтууд байгаа вэ?

Бид мэдээж гадаадын хөрөнгө оруулалт байгаа бол дэмжинэ. Энэ бол бид нарын бодож санаж явж байдаг эдийн засгийг өсгөх нэг том зүйл. Гэсэн хэдий ч аж ахуйн нэгжүүдээ бүгдийг нь цохиод унагачихгүй байх, өрсөлдөөнийг жигд авах тал дээр ямархуу заалт юмнууд байгаа вэ гэж.

Гуравдугаарт, тэр ноу-хау, техник технологитой холбоотой асуудал дээр давуу талууд оруулж ирэх. Энэ чинь ер нь л техник, технологийг нь оруулж ирэх, стандартыг нь өөрчлөх, бид нартай уялдаж байх гэх мэтчилэн энэ зүйл чинь зайлшгүй хийх ёстой зүйлүүд шүү дээ. Энэ дээр гурав дахь асуудал. Ямар дэмжлэг, юмнууд байж байгаа вэ гэдэг.

Тэгээд энэ бас нэг зүйл яригдаад яваад байна. Ерөөсөө энэ асуудлыг хэлэлцэхээс наана орж ирэхдээ уялдаад л бас нэг асуудал. Газартай холбоотой асуудал сая хальт яриад байх шиг байна. Одоо газрыг жишээ нь 15-аас 30 жил хүртэл гэрээний үндсэн дээр ашиглуулна гэж байгаа юм байна. Тийм үү? Ашиглуулья гэж байгаа юм байна.

Одоо манай жишээ нь Булган аймгийн хүрээнд гэхэд чинь аж ахуйн нэгжүүд яах вэ тэр тариалан эрхэлж байгаа хэд чинь 15, 15 жилээр л сунгаад яваа харагдаад байдаг. Нэг удаа 60-аар өгсөн. Бөөн хэл ам болсон байгаа.

Тэгэхээр энэ хуулийн заалт чинь дотоодын аж ахуйн нэгжүүдийнхээ хуулийн заалттай ерөнхийдөө барьж байгаа жишигтэйгээ хэр уялдаж байгаа юм. Зүгээр нэг л хардлага яваад байна шүү дээ. Аль аль талдаа. Ард иргэдийн хүрээнд ч гэсэн хардах нь зүйтэй. Бидний хүрээнд ч хардах нь зүйтэй л байх.

Тэгэхээр үүнийг зайлшгүй өнөөдрийн хурал дээр яриад, бүр тодруулаад явах нь зүйтэй байх. Ямар бодлого барьж байгаа вэ?

Дотоодын бид нарын аж ахуйн нэгжүүд, энэ газар тариалантай холбоотой, хүнсний ногоо тариалж байгаа холбоотой энэ хүмүүс маань хэд хэдээр сунгаад явж байгаа билээ. Эд нартайгаа уялдаж байгаа юу, үгүй юу? Энэ хугацаа маань гэж. Энэ дээр нэг хариулт өгөөч ээ.

**Ц.Цэрэнпунцаг:** Ч.Хүрэлбаатар сайд хариулья.

**Ч.Хүрэлбаатар:** Ж.Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулья.

Ер нь таны хэлж байгаатай санал нэг байна. Хөрөнгө оруулагч нар орж ирчхээд бидэнд хөнгөлөлттэй татварын орчныг бүрдүүлж өг гэж хэлэлцүүлгийн явцад маш цөөхөн гарсан. Ерөнхийдөө л хууль хэрэгждэг болгож өгөөч, шударга байгаач гэдэг ийм л зүйлүүд яригдаж байсан.

Тэгэхээр бид ийм хэд хэдэн зүйлийг энд оруулж өгсөн юм. Хөрөнгө оруулалт, худалдааны агентлаг гээд

манай яамны доор шинээр байгуулагдсан агентлаг байгаа. Энэ дээрээсээ нэг цонхны үйлчилгээг үзүүлнэ гэж байгаа юм. Хөрөнгө оруулагч нарт. Ийм зарчмын нэг өөрчлөлт орж ирсэн.

Дараагийнх нь, хөрөнгө оруулалтын асуудал өөрөө их олон талын асуудал хариуцсан байдаг тул төрийн бүх шатын байгууллагад Хөрөнгө оруулалтын хуулийн хэрэгжилтийг хангуулах, хөрөнгө оруулалтыг дэмжиж ажиллах талаар үүрэгжүүлсэн зохицуулалт оруулж ирж байгаа юм.

Өөрөөр хэлбэл төрийн байгууллагууд энэ хөрөнгө оруулалтыг дэмжих ёстой. Ингэж байж Монгол Улс хөгжихгүй бол энэ хөрөнгө оруулагч нарыг бас дэндүүлж байгаа шүү дээ. Манайхан. 16 жил шүүхээр явуулна. Зарим нь нэг цаас авах гэж, нэг гарын үсэг авах гэж хамаг юмаа зарцуулаад дуусгаж байгаа тохиолдлууд бий.

Уг нь тэр хөрөнгө оруулалт ирж байж, Монголд ажлын байр бий болж байж эдийн засаг тэлж өсч байдаг.

Тэгэхээр төрийн байгууллагууд дээрээ бид үүрэгжүүлж байгаа юм. Төрийн байгууллагуудын эрхийг нэмэхдээ биш, үүргийг нь нэмэх ийм өөрчлөлтүүд энд оруулж ирсэн гэдгийг хэлье.

Төрийн байгууллага нь хөрөнгө оруулалтын эрх ашгийг хөндсөн шийдвэр гаргах бол заавал урьдчилж санал авдаг сонсгол хийх нөхцөлийг нь энэ дотроо бүрдүүлж өгчихсөн байгаа. Өөрөөр хэлбэл хэн нэгэн хүн дураараа тэнд хэн нэгэн хөрөнгө оруулагчийн эрх ашигт нийцсэн шийдвэрийг ганц нэг талдаа хийгээд байхаар биш урьдчилж хэлж сануулж явж байгаад хийх ёстой гэдгийг оруулж өгсөн байгаа гэдгийг хэлье.

Газрын асуудал байгаа. Газрын асуудал бол яг одоо байгаа Хөрөнгө оруулалтын тухай хууль дээрээ 60 жилээр 12.1 дээр 60 жилээр эзэмшүүлж ашиглуулна. Тэгээд 40 жилээр хугацааг нэг удаа сунгаж болно гэдэг заалт одоо байгаа юм. Одоо мөрдөгдөж байгаа.

Тэгэхээр Үндсэн хууль дээрээ болохоор нөгөө эзэмшүүлнэ гэдэг гадаадын юунд байхгүй учраас бид нар энэ хууль дээрээсээ авчихсан байж байгаа. Тэгээд ер нь нэлээд ярьсан юм бид нар. Мэдээж зарим хүмүүс энэ газрын асуудлаар ийм юм хийх нь гээд попрод унана шүү дээ. Зүгээр байсан ч мушгиж ярих хүмүүс зөндөөтэй шүү дээ манайх чинь.

Тийм учраас бид нар аль болохоор хөндөхгүй. Одоо байгаа хууль эрх зүйн орчнуудаар нь л явж байгаа. Өөрөөр хэлбэл энэ дээр шинээр зүйл байхгүй. Газрын тухай хуулиараа явна. Мөн хүчин төгөлдөр мөрдөх гэж байгаа хуулийн заалтуудаар явна. Энэ дээр маш эмзэг байдаг учраас газрын асуудалд бид нар ч гэсэн эмзэг байдаг учраас одоо нэгэнт батлагдчихсан байгаа хуулийн хүрээнд л бүгдийг нь оруулж ирсэн гэдгийг хэлье.

Тэр нь Газрын хуулиар явна. Тийм. Түүн дээр ийм асуудал байгаа юм. Дотоодынхоо монопол ингээд байдаг. Ямар нэгэн нь орж ирчихээд монопол гээд.

Тэгэхээр энэ дээр ийм юм байгаа юм. Та бол өөрөө үүнийг эхлүүлсэн хүн өөрөө сайн мэдэж байгаа. МИАТ байгаа. МИАТ дээр гаднын нислэгүүдийг оруулж ирэхийг манайхан олон жил эсэргүүцсэн. Тэгээд үр дүн нь юу болсон бэ гэхээр монголчууд өндөр үнэтэй л билетээр явдаг байсан. Үүнийг либералчилж олон нислэгүүдийн тоог нэмэхийг та өөрөө сайд, бид хоёр хамт байж байхдаа та

өөрөө эхлүүлж байсан. Яг үүнтэй адилхан.

Юм тэлж байж дотоодын аж ахуйн нэгж ч гэсэн хүртэх хүртээмж нь нэмэгдэнэ. Жижигхэн байгаад байхаар энэ нь угаасаа энэ дотроо л хэрүүл нь явна. Томорвол олон ажлын байр, бусдад боломж бий болгоно гэдэг л агуулгаар хандаж байгаа юм.

**Ц.Цэрэнпунцаг:** Ж.Бат-Эрдэнэ гишүүн нэмж асуулт асууя.

**Ж.Бат-Эрдэнэ:** Ойлголоо. Ямар ч л байсан тэр дотоодын аж ахуйн нэгжүүд ер нь бол зах зээлээ өргөжүүлбэ гэж байгаа. Тийм үү? Орж ирчихээд өрсөлдөөнийг бий болгоё. Тэгж байж үнэ хямдарна. Тэгж байж хүртээмж сайжирна. Тийм үү? Энэ өнцгөөсөө харж байгаа юм байна.

Нэг мэдээллийн чанартай асуулт байна. Гадаад харилцааны яаман дээр гадаад худалдаа байсан. Тийм үү? Эдийн засаг, хөгжлийн яам тэр үйл ажиллагааг наашаа авсан байгаа билүү, үгүй билүү? Та сая газар бий болчихлоо гэж байна шүү дээ. Тийм ээ. Доороо танай яамны хүрээнд нэг газар худалдаа юутай холбоотой гэгчхэв. Газар гэв үү.

Тэгэхээр нөгөө Гадаад худалдааны тухай хууль гээд бид яриад байдаг шүү дээ. Ийм хууль маань хэзээ орж ирэх билээ, яах билээ. Энэ талаар тодруулж өгөөч.

**Ц.Цэрэнпунцаг:** Ч.Хүрэлбаатар сайд нэмж хариулья.

**Ч.Хүрэлбаатар:** Хөрөнгө оруулалт, худалдааны агентлаг гэж манай яамны доор байгуулагдсан.

Энэ нөгөө хуучнаар Гадаадын хөрөнгө оруулалтын агентлаг буюу



**FIFTA /Foreign Investment and Foreign Trade Agency/** гэж нэрлэгддэг ийм агентлаг шинээр бий болж байгаа гэсэн үг. Өөрөөр хэлбэл хуучин энэ агентлаг байхад бас тэнд гомдлоо яриад, асуудлаа яриад шийдээд яваад байдаг байсан юм нь алга болгоод хаячихсан учраас нэлээдгүй замбараагүй болчихсон.

Тэгэхээр одоо энэ агентлаг шинээр үйл ажиллагаагаа явуулахаар болж байгаа.

Гадаад худалдааны тухай хуулийг бид эхлээд уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортыг дэмжих тухай хууль дээр ажиллаж байна. Эхлээд үүнийгээ оруулчхаад дараа нь Худалдааны тухай хуульдаа өргөнө гэж бодоод одоохондоо түрүүн хэлсэн хууль, энэ хууль дээр ажилласан гэдгийг хэлье.

**Ц.Цэрэнпунцаг:** Д.Батлут гишүүн асуултаа асууя.

**Д.Батлут:** Өдрийн мэнд хүргэе.

Хөрөнгө оруулалтын тухай хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж байгаа. Тэгэхдээ ганц нэг тодруулах асуулт байна.

Ер нь гаднын хөрөнгө оруулагч нар тухайн улс оронд хөрөнгө оруулалт хийхдээ засаглалын тогтвортой байдал, хууль эрх зүйн орчны таатай нөхцөл байдлуудыг харж хөрөнгө оруулалт хийдэг.

Ер нь итгэлцэл дээр тогтсон ийм л зүйл явдаг гэж харж байна. Тэгээд яах вэ зарим гишүүд сая ярилаа. Монгол Улсад гаднын хөрөнгө оруулалтуудыг луйвардсан, хууль хяналтын байгууллагууд нь түүнд оролцсон ийм жишээнүүд бас нэлээд гарчихсан байгаа.

Энэ нь өөрөө гаднын хөрөнгө оруулагчдын итгэлийг алдах, Монгол руу хөрөнгө оруулалт хийх боломж бололцоо нэлээн саад тотгор болох ийм зүйлүүдийн нэг болж өгч байгаа.

Тийм учраас бид тэр хариуцлагатай холбоотой асуудал дээр нэлээн онцгой анхаарч явах ёстой гэдгийг гишүүд хэлж байгаатай санал нэг байгаа юм.

Тэгэхээр Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйл дээр Монгол Улсын Улсын олон улсын гэрээ соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ гээд заачихсан.

Монгол Улс гаднын гэрээ конвенцод нэгдэж орох юм бол тэр нь дотоодын хуультай ижил үйлчлэхээр заагаад өгчихсөн байгаа.

Тэгэхээр Монгол Улс гадаад улсын иргэн хоорондын хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх конвенцод 2000 оны 01 сарын 01-нд нэгдэн орчихсон байдаг юм байна.

Тэгэхээр бид энэ хуулийн төслийг боловсруулахдаа энэ конвенцтойгоо хэр уялдуулж өгсөн юм бэ?

Мэдээж олон улсын энэ гэрээ конвенцод нэгдэхдээ бид дотоодынхоо хуулийг бас нийцүүлсэн хэлбэрээр явж байх ёстой. Ингэж байж хөрөнгө оруулагч нарынхаа итгэлийг илүү баталгаажуулж өгөх тийм боломж бололцоо бүрдэнэ гэж харж байгаа юм.

Тэгэхээр энэ хуулийн төсөл дээр энэ гэрээ конвенцтой уялдуулсан хариуцлагын асуудал дээр энэ нөхцөлүүдийг тусгаж өгсөн зүйлүүд нь

хэр байгаа вэ гэдэг дээр нь хариулт өгөөч ээ гэж.

Хоёрдугаарт, нь олон гишүүд ярьж байна. Газрын асуудал. Үнэхээр эмзэг байгаа. Эхний удаа 60 жил ашиглуулах. Дараагийн удаад нөхцөл өөрчлөгдөхгүйгээр 40 жил гээд зүгээр ороод ирсэн байна.

Тэгээд саяын хариултаас арай өөр юм явж байгаа юм шиг байна. Тэгэхдээ энэ дотор бид зөвөөр тайлбарлаж ойлгуулах ёстой гэж харж байгаа. Одоо байгаа хуулийн төсөл дээр “эзэмшүүлэх”, “ашиглуулах” гэж байгаа. Эзэмшүүлэх гэдэг бол өөрөө нэлээн өргөн ойлголт байхгүй юу. Ашиглуулах гэдэг нь хязгаарлагдмал ойлголт.

Тэгэхээр ашиглуулах гэдэг зүйлээр ингэж оруулж ирж байгаа нь нэг талдаа зөв юм. Тэгэхдээ 100 жил байх нь энэ өөрөө бас асуудал дагуулж байна.

Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж 15 жилээр ашиглаж байгаа, эзэмшиж байгаа шүү дээ. Гэтэл гаднын хөрөнгө оруулагч нарт бид 60 жил, 100 жил. Нэмээд 40 жил ингээд нийлээд 100 жил болох гэж байна.

Тэгэхээр энэ тал дээр ер нь ямар бодлого барьсан юм бэ? Ер нь дотоодын аж ахуйн нэгж, иргэдээ дэмжих тал дээр яг энэ дээр зохион байгуулалт хийх, Газрын тухай хуультай холбоотой өөрчлөлтүүдийг хийх дээр ажлын хэсэг дээр ярьсан зүйл байгаа юу гэдэг дээр нь хариулт өгөөч ээ гэж хүсэж байна.

Ер нь зөв тайлбарлавал хүмүүс зөв ойлголт авах байх гэж бодож байгаа. Эзэмшүүлнэ гэдэг ойлголт чинь яг юу юм, ашиглуулна гэдэг нь өөрөө юу юм бэ гэдэг дээр нэлээн акцент өгмөөр санагдаж байгаа шүү гэдгээ хэлье. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Ч.Хүрэлбаатар сайд хариулъя. Ч.Хүрэлбаатар сайдын микрофоныг нээе.

**Ч.Хүрэлбаатар:** Д.Батлут гишүүний хөрөнгө оруулагчдын итгэлийг баталгаажуулах гэдэг асуудал зайлшгүй чухал. Итгэхгүй бол хэчнээн сайхан юм яриад хөрөнгө оруулалт орж ирэхгүй шүү дээ.

Тэгэхээр итгэлийг баталгаажуулах гэдэгтэй холбоотой зүйл дээр нэг жоохон тайлбар хэлье гэж бодож байна.

Хөрөнгө оруулагч нар орж ирэхдээ ерөөсөө л 4 эрэмбээр хуулийг хардаг.

Нэгдүгээрт нь, олон улсын ямар гэрээ конвенцод Монгол Улс нэгдэн орсон байна вэ.

Хоёрдугаарт нь, хоёр талт гэрээнүүдийг.

Нэгдүгээрт нь, олон улсын гэрээ конвенцуудыг харна. Дараагийнх нь, жишээлбэл Англиас орж ирж байгаа бол Английн Засгийн газар, Монголын Засгийн газар хоорондын хоёр талт ямар гэрээ хэлэлцээр байна вэ гэдгээ хардаг.

Тэгээд гуравдугаарт нь дотоодын хөрөнгө оруулалтын хууль. Тэгээд дөрөв дэх нь хөрөнгө оруулалтын гэрээгээ хардаг.

Ийм 4 зүйлийг ерөнхийд нь харж байж оруулж ирнэ.

Энэ дээр Монгол Улс харин хаа очиж олон улсын гэрээ конвенцод хариуцлагатай ордог. Ер нь ихэнхэд нь ордог.

Олон улсын гэрээ конвенц чинь манай хуулийнхан дээрээ байна шүү дээ.



Эхлээд энэ олон улсынхыг баримтална. Тэгээд түүнтэйгээ нийцүүлж явна.

Тэгэхээр одоо ингээд хөрөнгө оруулагч нарын гомдол яаж яваад байна вэ гэвэл ихэнх нь арбитр луу явдаг. Яагаад гэвэл энд олон улсын гэрээ конвенц дээр заагаад өгчихсөн байгаа учраас хүссэн хүсээгүй арбитр луугаа л яваад өгч байгаа юм.

Тийм учраас бид энэ зүйлүүдийг аль болохоор бага гаргаж байхын тулд гомдол гарсан тохиолдолд яаж шийдвэрлэх вэ гэдгийг нэлээд дэлгэрэнгүй байдлаар оруулж ирсэн гэсэн үг.

Хэлэлцүүлгийн явцад бид олон улсын бүх байгууллагууд, Элчин сайдын яамдад өгсөн, ирсэн саналуудыг бүгдийг нь авсан. Нийтдээ 60 хувийг нь авсан. 20 хувийн саналыг нь аваагүй. 20 хувийг нь зүгээр нэг сэтгэгдэл байсан учраас орхисон байгаа. Ийм байдлаар энэ дээр явж байгаа.

Тэгэхээр таны эхний асуулт конвенцуудтай хэр уялдсан бэ гэдэг асуудал.

Дараагийн асуудал дахиад газрын асуудал байгаа. Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Газрын тухай хуулийн 12.1.1-д газрыг 60 жилээр эзэмшүүлнэ, ашиглуулна. Нэмэх нь 40 жилээр нэг удаа хугацаа сунгаж болно гэдэг ийм зүйл ороод ирчихсэн одоо байгаа юм. Өмнөх хууль дээрээ.

Үүнээс “эзэмшүүлэх” гэдгийг нь бид аваад хаячихсан. Яагаад гэвэл Үндсэн хууль дээр асуудал.

Тэгээд дараагийн нэг зүйл нь. Та асууж байна шүү дээ. Эзэмшүүлэх тухай асуудал. **Эзэмшүүлэх нь ашиглахаас ямар ялгаатай юм бэ гэхээр “барьцаалж**

**болдог”, “шилжүүлж болдог”** зүйл байгаа шүү дээ. Тэр нь одоо байхгүй гэсэн үг.

**Барьцаалж болох, шилжүүлж болох гэдэг заалт нь энд алга болно гэсэн үг.**

Ажлын хэсэг дээрээ бид нэлээд удаан ярилцсан юм. Удаан. Тэгж тэгж байгаад ер нь энэ дээр тийм маргаан үүсгээд хэрэггүй. Хөрөнгө оруулалтынхаа хуулийг ярьж байж улсаа хорлох гэж байгаа юм шиг маргаан үүсгээд хэдүүлээ хэрэггүй. Үүсчихсэн байгаа гол асуудлуудаа шийдвэрлээд явъя.

Энэ нь дараагийн асуудал дээр Газрын тухай хуулийг тэр Хот байгуулалтын яам нь өөрөө оруулж ирэхдээ асуудлаа шийдвэрлээд яваг гэж үзээд бид маргаанаас зайлсхийгээд одоо байгаа хуулийн заалтуудаа хөндөлгүйгээр ороод ирсэн.

Гагцхүү Үндсэн хууль дээр тэр “эзэмшүүлэх” гэдэг зүйл байгаа учраас тэр үгээ аваад хаячихсан юм. Тэгэхгүй бол Ч.Хүрэлбаатар харсаар байж байгаад энэ “эзэмшүүлэх” гэдгийг албаар оруулж ирлээ гэж ярина шүү дээ.

Тийм учраас тэр заалтыг нь аваад хаячихсан байгаа гэдгийг хэлье.

**Ц.Цэрэнпунцаг:** Д.Батлут гишүүн тодруулж асууя.

**Д.Батлут:** Тийм.

Тэгэхээр манайхан олон улсын гэрээ конвенцод нэгдэнэ гэдэг маань өөрөө их чухал. Тэгээд Үндсэн хуульдаа бүр Монгол Улсын дотоод хуультай ижил хэмжээнд үйлчилнэ гэхихсэн.

Тэгэхээр аливаа хууль батлагдахдаа яг энэ гэрээ, конвенцод хэрхэн нийцэж байгаа вэ гэдэг байдлыг нэлээн судалж, бас тусгал болгож өгч байх хэрэгтэй юм шиг байгаа юм. Ингэж байж бидний үнэлэмж сайжирна. Цаашлаад.

Олон улсын гэрээ конвенцод нэгдчихсэн байдаг. Өөрсдийн боловсруулж гарч байгаа хуулийн төсөл нь тэс өөр заалтуудтай байгаад байх юм бол яг үндсэндээ Монгол Улс бол итгэлгүй улс. Магадгүй хууль эрх зүйгээр шийдвэрлэх боломж процесс нь ийм удаан байдаг энэ зүйл цаашдаа сайжрахгүйгээр он удаан жил үргэлжлээд байх нөхцөл байдлыг үүсгэх нөхцөл байдлыг бид нар бий болгочоод байгаа юм. Өөрсдөө.

Тэгэхээр энэ дээр манай хууль санаачилж оруулж ирж байгаа хүмүүс маань онцгой анхаарч.../минут дуусав/

**Ц.Цэрэнпунцаг:** Х.Ганхуяг гишүүн асуултаа асууя.

**Х.Ганхуяг:** Хөрөнгө оруулалтын хуулийг дэмжиж байгаа. Тийм.

Өмнө нь оруулаад тэгээд бас нэлээн маргаан дагуулчихсан. Түүн дээр зөвхөн бүртгэлийн асуудлыг хялбаршуулах асуудлыг л оруулж ирэхэд тос, усаараа ялгарч, Үндэсний аюулгүй байдлын асуудал хүртэл яригдаад л байсан.

Одоо бас яг л тийм асуудал давтагдах болов уу л гэж харагдаж байна. Энэ газрын асуудал сөхөгдөөд явж байгаа байдлыг харахаар.

Тэгээд Хөрөнгө оруулалтын хууль гэдэг маань үндсэндээ гадаад байна уу, дотоод байна уу ялгалгүйгээр хөрөнгө оруулалтын **бүртгэлийг нь хялбар байх**,

**өмчийг нь хамгаалах, өмчөө авч гарах нь хялбар байх** гээд ийм гурван гол асуудал байгаад байгаа юм л даа.

Тэгээд яах вэ, бүртгэл нь ойлгомжтой. Ингээд босгийг нь авчаж байгаа юм байна.

Нөгөө өмчийг нь хамгаална гэдэг маань саяын яриад байгаа, гишүүдийн ч яриад байгаа шүүх, шүүхийн шийдвэрийн асуудал байгаа юм. Яах вэ, шүүхийг бид арбитр гээд шийдэж болох юм шиг байгаа юм. Гэхдээ зардал аягүй их өндөр байдаг.

**Бид дотооддоо яг тэр арбитрыг нь нээж өгмөөр байгаа юм.**

Хоёрдугаарт, шүүхийн шийдвэр хэрэгждэггүй. Тэгээд шүүхийн шийдвэр хэрэгждэггүйг бид бүгдээрээ л мэднэ. Энэ чинь зөвхөн гадаадын иргэн байтугай дотоодын иргэд хүртэл гаргуулсан шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх гэж хэдэн жил гүйдэг.

Тэр хуучин өгдөг байсан урамшууллын тогтолцоог нь байхгүй болгочихсон юм шиг байгаа юм. Тэгээд түүнээсээ болоод шүүхийн шийдвэр хэрэгждэггүй нэг асуудал байгаа. Тэгээд үүнийг энэ хуулиараа бид дагуулж шийдсэн эсэх.

Хоёрдугаарт, хөрөнгө оруулалт орж ирнэ гэдэг маань зөвхөн мөнгө авчрахаасаа гадна эргээд нөгөө технологи, ноу-хау авчирдаг. Тэр нь эргээд нөгөө хүний нөөцтэй шууд холбоотой байдаг.

Тэгэхээр үүнтэй холбоотой хүний нөөц нь Монгол Улсад орж ирж ажиллах, тэр талыг нь хөнгөвчлөх асуудал энэ дээр орж ирж байгаа эсэх.

Үүнийг Г.Түвдэндорж сайд маш сайн мэдэж байгаа даа. Тийм ээ.

Одоо бид чинь гадаадаас ажиллах хүчин авна гэдэг нь маш хүндрэлтэй болчихсон шүү дээ. Тэгээд өндөр мэдлэг, ур чадвартай ноу-хау мэдлэг гадаадын боловсон хүчнийг Монголд авчрахаар ямар нэг хөнгөлөлттэй нөхцөл орсон эсэх. Үүнийг бас тодруулчихмаар байна.

Дөрөвдүгээрт, гадаадын иргэн. Одоо энэ газрыг л их яриад байна л даа. Тэгэхдээ гадаадын иргэд газар луу хөрөнгө оруулалт хийнэ гэхээсээ илүү үл хөдлөх байдаг юм уу, эсвэл уул уурхай гэдэг рүүгээ илүү их ач холбогдол өгч байгаа гэж харж байна.

Тэгээд Ашигт малтмалын хууль талд ямар нэгэн өөрчлөлт дагуулаад орох эсэхийг бас тодруулчихмаар байна.

Тавдугаарт, гадаадын иргэд үл хөдлөх худалдаж авахад жоохон хүндрэлтэй байдаг гэж ойлгосон. Тэгээд тэр асуудал үүгээр хөндөгдсөн эсэхийг бас тодруулчихмаар байна.

Дээрээс нь, данс их битүүмжилдэг. Одоо хэчнээн төрийн алба татвараас гадна аж ахуйн нэгж, иргэний дансыг харах, шалгах, битүүмжлэх хэрэгтэй байдаг вэ? Энэ тал дээр ямар нэгэн хамгаалалтын арга хэмжээ авсан эсэхийг бас тодруулчихмаар байна.

Тэгээд сүүлийн асуулт нь, энд чинь үйл ажиллагаа явуулж байгаа нөгөө гадаадын иргэн ч байдаг юм уу, юу ч байдаг юм буцаад гарч явах асуудал байгаа шүү дээ.

Тэгэхээр компаниа татан буулгах гэхээр хэдэн жил болдог. Энэ талын зохицуулалтууд яг энэ хуулиар хөндөгдөж байгаа эсэхийг бас тодруулчихмаар байна. Баярлалаа.

**Ц.Цэрэнпунцаг:** Ч.Хүрэлбаатар сайд хариулъя. Дараа нь ажлын хэсэг бэлдэж байгаарай.

**Ч.Хүрэлбаатар:** Дутуу хариулсныг манай ажлын хэсгийнхэн хариулаарай.

Би Х.Ганхуяг гишүүний хэлж байгаа олон зүйлтэй санал нэг байгаа. Бүгдийг нь хийгээд оруулаад ирье гэхээр яг үнэнийг хэлэхэд бас хэцүү.

Тухайлбал, газрын тухай асуудлыг бид яагаад хөндөхгүй байгаа юм бэ, яагаад Газрын тухай хууль яг хэвэндээ, Хөрөнгө оруулалтын хуульд хэвээрээ байсан бэ гэхээр ер нь газартай холбоотой асуудлыг Хот байгуулалтын яам үүнийг өөрсдөө оруулж ирээд шийдэг гээд бид түүнд ороогүй гэдгийг онцолж хэлмээр байна.

Тэгээд 5 хоногийн дараа Монгол Улсын эдийн засгийн чуулга уулзалт болно. Нэлээд томоохон хөрөнгө оруулагчидтай. Тэнд энэ хуулийн хэлэлцүүлгийг бид тодорхой хэмжээгээр хийгээд явах юм.

Тэгэхээр нэг их олон тийм маргаантай асуудлуудаар үүнийг оруулъя гэсэн тийм бодол байгаагүй шүү.

Тийм учраас бид та бүгдийн санаачилсан хуульд хэр зэрэг маргаан өрнөж байсныг санаж байгаа учраас тэр хурц хурц асуудлуудын заримыг нь хийгээгүй.

Гэхдээ хийх ёстой, зайлшгүй хийгдэх ёстой зүйлүүдийг бид хийсэн гэдгийг хэлье.

Гадаад дотоод гэж ялгадаг юмнуудыг бүгдийг нь алга болгочихсон гэсэн үг. Тэр авдаг мөнгөн дээр, өгдөг

хугацаа нь ерөнхийдөө бүгдээрээ адилхан хэмжээнд очсон байгаа.

Шүүхийн шийдвэрийг гүйцэтгүүлдэггүй гэдэгтэй санал нэг байгаа. 100 төгрөгийн шүүхийн шийдвэр гаргахад ерөөсөө 10 хувь нь л хэрэгждэг. 90 хувь нь хэрэгждэггүй.

Гэхдээ энэ чиглэлээр бид өөрчлөлтийг оруулаагүй. Яагаад гэвэл тухайн хууль эрх зүйн орчноо, хариуцсан сайд нар нь асуудлаа шийдээд. Бид Хөрөнгө оруулалтыг дэмжих тухай хуулиар чинь шүүхийн юмнуудыг яриагүй.

Гэхдээ ийм ийм ноцтой асуудлууд энэ дээр удаа дараа яригдаж байгааг сайжруулах ёстой шүү. Энэ дээр та бүгд санал санаачилгатай ажиллаач ээ гээд холбогдох яг энэ асуудлыг хариуцаж байгаа хүмүүст нь ярьсан гэдгийг хэлье.

Монгол Улс гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх конвенцод нэгдээд орчихсон. Нью-Йоркийн конвенцод нэгдээд орчихсон байгаа.

Тэгэхээр гадаад улсын арбитрын шийдвэрийг Монгол Улс биелүүлэх үүргээ хүлээчихсэн. Хэрвээ биелүүлэхгүй бол түүнтэй холбоотой торгууль, хариуцлага нь дагаад эрчимтэй явагддаг гэдгийг хэлье.

Ингээд үлдсэнийг нь манай ажлын хэсгийнхэн Г.Түвдэндорж сайд, Б.Анар дарга нар хариулаарай.

**Ц.Цэрэнпунцаг:** Ажлын хэсгийн 3 номерын микрофоныг нээе.

**Б.Анар:** Эдийн засгийн хөгжлийн яам Б.Анар. Х.Ганхуяг гишүүний асуултад хариулъя.

Сая асуусан асуултуудаас ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх, виз, оршин суухтай холбоотой асуудал, инновацийн хөнгөлөлт чөлөөлөлттэй гээд татварын бус урамшуулалтай холбоотой асуудлууд Хөрөнгө оруулалтын хууль дээр байсан. Яг тэр хуулийнхаа дагуу байгаа.

Энэ зохицуулалтууд нь давхар салбарынхаа хуулиуд дээр энэ урамшуулал олгож байгаа, хөнгөлөлт чөлөөлж байгаа асуудлууд нь бас давхар яг нийцэл нь байгаа учраас энэ хууль дээр яг хэвээрээ байгаа гэж ойлгож болно.

Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл хэлэлцүүлэг нь хийгдээд явж байгаа.

Тэгээд яг бид нарын бодож байсан өөрчлөлтүүд тухайн төслүүд дээрээ тусчихсан явж байсан учраас бид хэд энэ өөрчлөлтүүд рүү Хөрөнгө оруулалтын тухай хуулиар дагаж ороогүй.

Орон нутгийн чиг үүрэг гээд төрийн байгууллагууд яг ямар үүрэг хөрөнгө оруулалтын чиглэлээр хүлээх юм бэ гэдэг өөрчлөлтийг хууль дээрээ тусгасан. Энэ дээр тухайлаад хэлэх юм бол төрийн бүх шатны байгууллагууд нь хөрөнгө оруулагчтай холбоотой хөрөнгө оруулагчийг хамгаалах чиглэлийн үүргийг хэрэгжүүлнэ гэж зааж өгсөн.

Төрийн байгууллага нь хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хөндсөн аливаа шийдвэр гаргаж байгаа бол урьдчилж заавал санал авдаг, сонсгол хийдэг байх, захиргааны ерөнхий хуулийг биелүүлдэг байх ийм нөхцөлийг Хөрөнгө оруулалтын тухай хууль дээрээ зааж өгсөн.

Хэрвээ энэ сонсголыг хийгээгүй бол тухайн хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хохироож байгаа аливаа шийдвэр нь буцаад хүчингүй болно гэсэн заалтыг хийж өгч байгаа.

Энэ нь эргээд хөрөнгө оруулагч аливаа гомдол маргаанаа шийдүүлээд явахад энэ хуулийн заалтаар хамгаалагдах нэг үндэслэл болж өгч байгаа.

Үүн дээрээ нэмээд төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хөрөнгө оруулагч хохирсон нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон. Аливаа юу гэдэг юм, шүүхийн шийдвэрээр юм уу, хөрөнгө оруулагчийн эрх ашиг нь хохирох байсан байна гэдэг нь тогтоогдож байгаа бол тэрийг эргээд төрөөс буцааж хариуцаж төлдөг. Төр энэ хариуцаад төлсөн төлбөрөө эргээд тухайн буруутай анхан шатын шийдвэрийг гаргасан тэр төрийн албан хаагчаар нь хариуцлага тооцдог, эргүүлж төлүүлдэг байх тухай заалтыг яг Хөрөнгө оруулалтын тухай хууль дээр дэлгэрэнгүй оруулж тусгасан байгаа.

**Ц.Цэрэнпунцаг:** Х.Ганхуяг гишүүн тодруулж асууя.

**Х.Ганхуяг:** Би ганцхан л юм асууя даа.

Дэлхийн банкнаас нэг судалгаа хийдэг шүү дээ. Бизнес орчны судалгаа хийгддэг. Одоо хийгдэхээ больчихсон юм шиг байгаа юм. Хамгийн сүүлийнх нь 2022 онд хийгдсэн санагдаж байна. Манайх чинь түүгээр 81-д орсон байдаг.

Яах вэ, бизнесийн орчны судалгаа гэдэг үндсэндээ хөрөнгө оруулалтын орчинтой л зүйрлэж болохоор байгаа байхгүй юу. Тэр чинь бүртгэлд шаардагдах хугацаа, шийдвэр гарах хугацаа, зөвшөөрөл авахад шаардагдах хугацаа гэх мэтчилэн олон асуудлуудыг тэр судалгаагаар хийгддэг.

Тэгээд манайх чинь 81-д явдаг. Тэгээд яг бид нартай адилхан ижил гараатай байсан. Хэлэх юм бол Гүрж ч байдаг юм уу, Эстони ч байдаг юм уу. Эд нар нэг нь 7, нөгөөдөх нь 11-д ороод явж байдаг байхгүй юу.

Яах вэ, мэдээж Хөрөнгө оруулалтын хууль батлагдсанаар ингээд өргөс авчихсан юм шиг бид бүх асуудлаа шийдэж чадахгүй л дээ. Гэхдээ энэ хууль батлагдсанаар одоо ер нь ямар хүлээлттэй байгаа вэ? Магадгүй тэр 81 нь хэд дээр очих нэг тийм хүлээлтийн тооцоо судалгаа байдаг уу гэдгийг л асуучихъя.

**Ц.Цэрэнпунцаг:** Ажлын хэсгийн 3 номероос хариулъя.

**Б.Анар:** Х.Ганхуяг гишүүний асуултад тодруулж хариулъя.

Дэлхийн банкны “**Doing Business**” судалгаагаар өгч байсан зөвлөмжүүдийг бүгдийг нь бид нягталж харсан.

Зөвхөн 2020 он гэлтгүй, 2019 он, өмнөх жилүүдэд хийгдэж байсан. Одоо ахиж хийгдэхгүй байгаа. Нэр нь өөрчлөгдөөд ахиад хийгдэж байгаа.

Энэ дээр Монгол Улсын хамгийн муу байр эзлүүлээд байгаа хоёр, гурван үндсэн том шалтгаанууд байгаа. Хамгийн эхний хамгийн муу нөлөө үзүүлж байгаа нь энэ шууд болон шууд бусаар хөрөнгө оруулагчдын хөрөнгийг хурааж авч байна гэдэг ийм заалт байгаа.

Энэ дээр манай улс нэлээн хойгуур байр эзэлж байсан.

Хоёрт, төрийн байгууллагуудын дарамт шахалт. Ялангуяа төрийн босоо, хэвтээ удирдлагатай байгууллагууд давхардуулан шалгалт хийдэг. Бидний хийж байсан судалгаан дээр Баянхонгорт нэг аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд

жишээ нь нэг жилдээ 30 гаруй удаа давхардаад хяналт шалгалтыг оруулсан байна гэдэг ийм дүн гарч ирсэн.

Тэгэхээр үүнтэй холбоотой хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх ашгийг нь хамгаалах хөрөнгө оруулалтын баталгаа. Аливаа байдлаар хөрөнгө оруулагчийн.../минут дуусав/

**Ц.Цэрэнпунцаг:** О.Цогтгэрэл гишүүн асуулт асууя.

**О.Цогтгэрэл:** Хөрөнгө оруулалтын хууль чухал хууль орж ирж байна.

Тэр тусмаа яг өнөөдөр бодит нөхцөл байдал дээр хөрөнгө оруулалт дотроо гадаадын хөрөнгө оруулалт, тэр тусмаа уул уурхайн бус хөрөнгө оруулалт гэдэг зүйл Монгол Улсад өнөөдөр бараг тэгтэй тэнцүү гэж хэлэхэд болохоор ийм нөхцөл байдалтай.

Үүнийг дагаад эдийн засгийн өсөлт, хөгжилтэй холбоотой олон зүйл дээр хойш нь татаж байгаа. Техник, технологи, шинэ ноу-хау орж ирэхгүй олон зүйл болчихсон байгаа нь тодорхой. Ийм учраас их чухал юм.

Тэгээд хуулийг ингээд уншиж судалж үзэхээр. Яах вэ, энэ удаад гадаадын хөрөнгө оруулалт гэдэг рүү би түлхүү ярьчихъя л даа.

Гадаадын хөрөнгө оруулалт орж ирэхгүй байгаа шалтгааныг яг юу гэж оношилсон юм? Үнэхээр тэр хууль эрх зүйгээс, шударга бус шүүхээс болоод байна уу? Аль эсвэл тэр татварын их бага ачааллаас болоод байна уу? Аль эсвэл татварын болоод энэ эрх зүйн тогтворгүй орчноос болоод байна уу?

Энэ олон зүйлүүдийн онош нь яг хаанаа юм бол?

Хэрвээ эд нар дээр онош байна гэвэл энэ хуулийг уншаад харахаар тэр хууль шүүхтэй холбоотой харилцаа хууль шүүхийнхээ хуулиар явна. Арбитр арбитраараа явна. Хууль энэ дээр асуудлыг шийдэж чадахгүй.

Тэр маргаан таслах зөвлөл гэдэг чинь үндсэндээ урьдчилсан хэлэлцүүлэг шиг хоорондоо ярилцаад болохгүй бол арбитр, шүүхээрээ явах юм байна.

Энэ хууль шүүх шударга бус, хөрөнгө оруулагчдын итгэлийг алдаад байгаа зүйл дээр энэ хууль ямарваа нэгэн хариулт өгч чадахгүй юм байна. Татвартай холбоотой зүйлийг харахаар татварын тэр хөнгөлөлт чөлөөлөлттэй холбоотой зүйлүүд чинь татварын хуулиар зохицуулна гээд энэ дээр нэг өгүүлбэр харагдаж байх шиг байна. Татварын хуулиараа тэр хөнгөлөлт чөлөөлөлтийг зохицуулна.

Энэ дээр ямарваа нэгэн дэмжлэг болоод хөрөнгө оруулагч, тэр тусмаа гадаадын хөрөнгө оруулагч, тэр тусмаа уул уурхайн бус салбарынханд ямарваа нэгэн өөр нөхцөл яг энэ хуулиар шинээр юм өгөхгүй юм байна.

Тэгэхээр энэ хууль гарснаар тэр хөрөнгө оруулагчдад, тэр тусмаа тэр гадаадын гэж байгаа хөрөнгө оруулагчид яг ямар давуу талууд үүсэх юм? Хууль шүүх болоод татвар чинь энэ хууль дээр тодорхой заалтууд бас харагдахгүй байгаад байна шүү дээ.

Тэгэхээр яг энэ дээр яг ямар ингээд дүгнэлтүүд, гол шалтгаан дээрээ ямар дүгнэлтүүд хийгээд тэр дээрээ ямар хариултууд өгч байгаа вэ? Үүнийгээ нэг илүү тодорхой ач холбогдлын зэргээр нь хэлээд өгөөч ээ.



**Ц.Цэрэнпунцаг:** Ч.Хүрэлбаатар сайд хариулья.

**Ч.Хүрэлбаатар:** О.Цогтгэрэл гишүүний асуултад хариулья.

1990-2023 оны ингээд 1 дүгээр улирлын байдлаар аваад үзэх юм бол Монгол Улсад нийтдээ 41.1 тэрбум долларын гадаадын хөрөнгө оруулалт орж ирснээс 73 хувь нь уул уурхайн салбарт, 11 хувь нь худалдаа, үйлчилгээний салбарт. Тэгээд үлдэж байгаа 16 салбар бол бусад бүх салбарт хийгдсэн хөрөнгө оруулалт байгаа.

Тэгээд бид энэ хуулийн хэлэлцүүлгийг нийтдээ 65 хоног, тэгээд хөрөнгө оруулагч нар, бизнесийн зөвлөлүүд, мэргэжлийн холбоод, гадаадын Элчин сайдын яамд, олон улсын банк, санхүүгийн байгууллагуудтай хэлэлцүүлэг хийгээд тэгээд ерөнхийдөө ямар байдалд нэгдүгээрт нөлөөлж байна вэ гэвэл манай хуулийн, улс төрийн, эдийн засгийн тогтворгүй байдал хамгийн голлож нөлөөлж байна гэж үзэж байгаа юм.

Тийм учраас энэ хуульдаа нэгдүгээрт нь.

Дараагийнх нь, энэ хуулийн маргаанууд, хөрөнгө оруулагчийн маргааныг шийдвэрлэж байгаа зүйл үнэхээр сэтгэлдээ огтхон ч нийцэхгүй байна. Зарим шүүхээр 16 жил явсан тохиолдол байгаа юм.

Тэгэхээр энэ маргааны асуудлыг бид зөв шийдвэрлэдэг болъё гэдэг зүйлээр үүнтэй холбоотой нэлээдгүй заалтуудыг оруулж ирсэн.

Татварын асуудлаар нэлээд ярьсан. Тэгээд угаасаа Монгол Улсад татвар ноогдуулах, татвартай холбоотой асуудлууд, дараа нь тэр акт, торгууль

тавих эд нар бүгдээр татварын хуулиар яригддаг учраас энэ дээр горьдоод байгаа юм шиг, эсвэл бусад хуультайгаа зөрчилдөж байгаа юм шиг Хөрөнгө оруулалтын тухай хуульд татвартай холбоотой заалтыг оруулах шаардлагагүй гэж үзсэн байгаа. Харин ч судалгаагаар хавтгайрсан татварын хөнгөлөлт нь хөрөнгө оруулалтыг татах нөхцөл болдоггүй.

Хамгийн гол нь маргаан үүслээ гэж бодоход тэрийг ямар ч Засгийн газар нь ч бай, ямар ч тохиолдолд бай шийддэг арга зам нь маш ойлгомжтой байхыг л хүсдэг юм билээ.

Тэгээд үүнтэй холбоотой заалтуудыг энд оруулж ирж өгсөн. Өөрөөр хэлбэл бид татварын ямар нэгэн нэмж хөнгөлсөн тийм зүйл байхгүй.

Одоо зарим газар очихоор юу гэдэг юм, гадаадын хүн орвол өөр үнэ авдаг, дотоодынх болохоор өөр төлбөр авдаг нэг ийм нөхцөлүүд байгаад байдаг шүү дээ. Ялангуяа одоо юу гэдэг юм, Хойд Солонгос болон тиймэрхүү засаглалтай улсуудад их түгээмэл ажиглагддаг ийм зүйл.

Тэгэхээр ерөөсөө л хөрөнгө оруулагч нар маань бид нарт дотоодынх дээр болохоор өөр нөхцөлтэй, өөр хугацаатай ийм юм тавиад байх юм. Үүнийгээ адилхан болгож өгөөч ээ л гэдэг маш энгийн хүсэлтүүд. Тэгээд маргаан гарна. Аль ч нийгэмд аль ч засаг байхад маргаан бага гарахыг бид ойлгож байгаа.

Гэхдээ энэ шийдэгддэг нь олон улсын жишигт нийцсэн ийм хэлбэрээр шийдэгдээд явахад бид бүх нөхцөл бололцоогоороо үүнийг ашиглана шүү дээ гэдэг ийм зүйл хэлсэн гэдгийг хэлье.



Тэгээд дээр нь төрийн зүгээс ямар ч шаардлагагүй төрөл бүрийн дарамт нэхсэн, зөвшөөрөл, бичиг ийм зүйлүүдийг л хялбарчлаад өгөөч, энгийн болгоод өгөөч. Тэгвэл хөрөнгө оруулахад болно.

Монгол бол хөрөнгө оруулалт оруулахад таатай орны нэг хэвээрээ байгаа гэдгийг нь хэлж байгаа. Удаа дараа хэлж байгаа. Ер нь одоо ч гэсэн тийм байдалд байна.

Харин бид яг тэд нарын хүсээд байгаа гол гол зарим нэг зүйл, заалтуудыг бид нар өөрчлөөд зөв болгоод явчих нь оновчтой болов уу гэсэн ийм байдлаар энэ өөрчлөлтийг оруулж ирсэн гэдгийг хэлье.

**Ц.Цэрэнпунцаг:** О.Цогтгэрэл гишүүн нэмж асууя.

**О.Цогтгэрэл:** Саяын тэр гадаадын хөрөнгө оруулалт дээр хууль, шүүх, шударга бус байдал. Мэдээж энэ бол асар чухал анхаарал татах асуудлууд.

Энэ дээр нэмээд хоёр зүйл бидэнд их түвэг авчирч байгаа юм шиг л төсөөлөл надад байдаг.

**Нэгдүгээрт нь, газар зүйн байршил.**

Манайх чинь татвар багатай орон гэж өөрсдийгөө хэлдэг. Гэтэл манай газар зүйн байршил чинь өөрөө асар өндөр татвартай. Магадгүй тооцоолоод хэлбэл 20, 30-иар Хятадад, Орост, одоо энэ Зүүн Өмнөд Азид бизнес эрхэлснээс манай газар зүйн байршил асар өндөр татвартаа орно.

Тийм болохоор заавал татварын орчин, нөхцөлийг бид шинээр эргэж харах ёстой л гэж боддог.

**Хоёрдугаарт нь, инфляц.**

Гаднаас валют авчраад буцаагаад төгрөгөөр гарна. Саяын татварууд нь бага юм шиг мөртлөө жилдээ хоёр оронтой тоотой мөнгөний ханш нь уначихдаг.

Тэгэхээр энэ чинь өөрөө дахиад тэр газар зүйн байршил дээрээ нэмээд дахиад хоёр оронтой тоотой татвар бид нэмээд авчихдаг.

Тэгэхээр энэ нь өөрөө эдийн засгийн суурь орчны хувьд.../минут дуусав/

**Ц.Цэрэнпунцаг:** Ч.Хүрэлбаатар сайд нэмж тодруулж тайлбар өгье.

**Ч.Хүрэлбаатар:** Тийм. О.Цогтгэрэл гишүүнтэй санал нэг.

Ер нь далайд гарцгүй, хол зайтай байдаг нь өөрөө манай өртөг зардлыг нэмэгдүүлдэг зүйл байгаа.

Инфляцтай ч гэсэн санал нэг байна. Хөрөнгө оруулагч эдийн засгийн тогтвортой нөхцөл байдлыг л хүсээд байгаа юм. Эдийн засгийн өсөлт нь өндөр. Одоо 6 орчим хувь дээр байдаг ч юм уу, инфляц нэг оронтой тоон дээр тогтвортой явах, зээлжих зэрэглэл нь дандаа нэмэгдэж байдаг, гаргаж байгаа шийдвэрүүд нь ойлгомжтой байх ийм л орчныг Монголд хөрөнгө оруулалт хийж байгаа хүмүүс хүсээд байгаа юм.

Байж байгаад л инфляц нь юу гэдэг юм, 4, 5 хувь руу уначхаад л, нэг мэдэхэд эргээд л 16 хувь руу ороод л. Валютын нөөц нь нэг болохоор өсөөд л, нэг болохоор унаад л. Түүнийгээ дагаж төгрөгийн ханш нь хэлбэлзээд байгаа нь өөрөө хөрөнгө оруулагч нарт аягүй хортой.

Үүнийг л бид хэвийн болгохын тулд экспортоо нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтыг татаж оруулах ийм л ажлуудыг улам цаашдаа тууштай.../минут дуусав/

**Ц.Цэрэнпунцаг:** Т.Доржханд гишүүн асуултаа асууя.

**Т.Доржханд:** Хуулийн төслийг дэмжиж байна. Тэгэхдээ бас нэг жаахан залруулга хийхгүй бол.

Саяын эцсийн яриа бол инфляц биш шүү. Ханш шүү.

Инфляц, ханш хоёрыг зааглаж ярихгүй бол одоо Монголбанк чинь ингээд бид нарт ханш хамаа байхгүй. Манай Монголбанкны Төв банкны үндсэн зорилго инфляц гээд target-лаад байдаг байхгүй юу.

Гэтэл анхны тэр Чилийн хуулиас оруулж ирсэн нь ханш байхгүй юу. Хөрөнгө оруулагчдад хамгийн чухал юм бол ханш шүү.

Өнөөдөр 1200 төгрөг байхад тухайлбал 2012 онд солиулж орж ирчхээд 3 жилийн дараа 2015 онд 2400-гаар мөнгөө солиулж авахаар шууд хоёр дахин алдагдалд орж байгаа юм.

Түүнээс хойш дахиад ханш 60 хувь уначхаад байгаа. 60 хувь уначхаад байгаа.

Тэгээд ханшийг хэн хариуцах ёстой юм гэхээр Төв банк нь хариуцдаггүй. Энэ чинь бид нарын асуудал биш шүү дээ. Засаг руугаа шиддэг. Тэгээд хоорондоо бөмбөг шидэж явсаар байгаад хөрөнгө оруулалт байхгүй болчихоод байгаа шүү. Тэгээд үүнийгээ Эдийн засгийн байнгын хороон дээр эдийн засагчид юм бол үүнийгээ тодорхой ойлголттой байхгүй бол энэ

инфляц гээд ингээд далийгаад явчих юм бол энэ чинь шал өөр бодлогын зорилт болно шүү. Үүнийг би зүгээр нэг тодруулаад хэлчихмээр санагдлаа.

Тэгэхээр гурван зүйл байна. Яагаад манай эдийн засаг 12 тэрбум доллар дээр гацчихаад байгаа юм бэ гэдэг юм. Төгрөгөөрөө өсөөд л байдаг. Гацдаг. Яагаад вэ гэхээр экспорт нь хэлбэлздэг. Нүүрсээ гаргаж чадахгүй бол уначихдаг. Байхгүй бол болдоггүй.

Хоёр нь, гаднын хөрөнгө оруулалт байхгүй. Сүүлийн 10 жил байхгүй.

Гуравт нь, өрийн хязгаар нь тулчихсан. Жаахан өрөө тасалгаа гарах юм бол өрийн дахин санхүүжилт хийдэг. Өөр орон зай байдаггүй. Ингээд л 12, 13-хан тэрбум доллар дээрээ гацчихсан.

Тэгэхээр одоо ингээд эдийн засгаа тэлье ээ л гэж байгаа юм бол бид нар чинь валютын орох урсгалыг л нээнэ гэсэн үг шүү дээ. Энэ гурван урсгалыг л нээнэ.

Гэтэл гурав дахь нь цоожтой. Эхний хоёр нь боломжтой. Гэхдээ хоёр дахь дээр нь бид нар одоо анхаарах нь зүйтэй байгаа юм.

Тийм ч агуулгаараа энэ хуулийн төсөл орж ирж байгаа гэж бодож байгаа. Гаднын шууд хөрөнгө оруулалт.

Одоо бүгдээрээ сая Хятад руу яваад үзлээ шүү дээ. КОВИД-ын үеэр эдийн засаг хаачихсан. Харагдах байдлаараа гоё хот байдаг. Гэтэл бизнес нь царцчихсан, хөрөнгө оруулалт нь царцсан. Гадаад хүн бараг харагдахгүй л байгаа биз дээ.

Тэгээд л эдийн засгийн **stagnation**<sub>[зогсонги байдал]</sub> тэнд үүсэж байгаа байхгүй юу.

Тэгэхээр гаднын хөрөнгө оруулалт ямар хэрэгтэй юм бэ гэдгийг Хятадын бизнесүүд өөрсдөө яриад байна шүү дээ. Бид нарт гаднын хөрөнгө оруулалт хэрэгтэй байна гээд.

Ийм болохоор энэ том эдийн засгийн хоёр дахь. Тийм ээ. Том super power гээд байгаа улс чинь өөрөө борцлогдоод байна. Гэтэл Монголын эдийн засаг 10 жил борцлогдчихлоо.

Одоо үүнийгээ услахын тулд гаднаас хөрөнгө оруулалтаа татах л хэрэгтэй. Татахын тулд яаж татах юм бэ гэхээр би сая О.Цогтгэрэл гишүүний саналтай ижил байна. Байгалийн нөхцөл чинь өөрөө өндөр татвар байна гэж. Үнэн шүү дээ.

Монголд оруулж байгаа хөрөнгө оруулалт ганцхан л уул уурхай. Тэр нь Хятад руу зардаг. Бусдад нь ашиг байхгүй. Хөрөнгө оруулаад ч нэмэр байхгүй ийм л бизнесийн модель яваад байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ рүүгээ чиглэсэн ямар бодлого байна вэ? Татварын хөнгөлөлтүүдийг татварын хуулиараа гэж байгаа юм байна. Тэгвэл татварын бус ямар хөнгөлөлтүүд байгаа юм бэ? Энэ дээр нэг тодорхой хариулт өгмөөр байна. Яг ямар хөнгөлөлтүүд байгаа юм?

Монгол хүн бизнесээ хийх, гаднын хүн орж ирж бизнесээ хийх чинь ялгаатай шүү дээ. Ижилхэн түвшинд авч үзэх юм бол хөрөнгө оруулалт чинь өсөхгүй шүү дээ.

Дэлхий дээр хөрөнгө оруулалтыг татаж хөнгөлөлтүүдийг өгдөг болохоос биш ижилхэн орчин өгөх юм бол саяын давагдашгүй нөхцөл байдал чинь хаалт болчихно.

Хоёрт нь, шүүхийн шийдвэрийн процесс дээр хамаг бизнесүүд гацчихдаг. Хөрөнгө оруулагчдаа дээрэмдээд, тоноод, хөөгөөд явуулчихдаг. Эрх мэдэлтэй нөхдүүд нь хориод, цагдаад, юмыг нь булаагаад авдаг. Энэ маш муухай түүх шүү дээ. Худлаа ярьдаг, хулгай хийдэг, тэгээд дээрэмддэг, шүүх, цагдаагийн байгууллагатайгаа нийлж явдаг.

Яг энэ дээр ямар зохицуулалт орж байгаа юм бэ? Яг энэ хоёр асуудал дээр тодорхой хариулт авмаар байна. Баярлалаа.

**Ц.Цэрэнпунцаг:** Ч.Хүрэлбаатар сайд хариулъя.

**Ч.Хүрэлбаатар:** Т.Доржханд гишүүн ээ, би их тодорхой л хариулаад байгаа юм гэдгээ хэлье. Нэгдүгээрт нь.

Хоёрдугаарт нь, санал нэг байна. Гадаадын хөрөнгө оруулалтыг татах битгий хэл зүгээр манай үндэсний хөрөнгө оруулагч нар, бизнесменүүд үйл ажиллагаагаа явуулахад эдийн засгийн тогтвортой байдал үнэхээр зайлшгүй хэрэгтэй. Тэнд ханш орно, инфляц орно. Аль аль нь орно. Тэгж байж бид хөрөнгө оруулалтаа хийх таатай орчныг бүрдүүлээд явна.

Хэрвээ бизнес хийгээд явж байтал нөгөө бизнесийнхэд нь түүхий эд болдог материалын үнэ өсөөд байвал тэр компани бүтээгдэхүүнийхээ үнийг нэмэхээс өөр аргагүй байдалд орно шүү дээ.

Тэгэхээр инфляц ханш аль аль нь зайлшгүй шаардлагатай.

Тийм учраас хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэхэд макро эдийн засгийн таатай орчныг бүрдүүлэх нь хамгийн чухал гэдэгтэй санал нэг байна.

Тэгээд өнгөрсөн хугацаанд таны ярьж байгаа олон зүйл эдийн засгийн тогтвортой байдлыг бий болгох, зөв бодлого явуулахад хувь нэмрээ оруулсан гэдэгт би санал нэг байдаг. Тэгж ч боддоггүй.

Харин нэг зүйлтэй санал нийлэхгүй юм байна.

Хэдүүлээ нэг юмыг дэмжихийн тулд бусдыг нь доошоо хиймээргүй байгаа юм. Аль альныг нь дэмжмээр байгаа юм. Уул уурхайн салбараа ч дэмжмээр байна.

Тэгэхээр хөрөнгө оруулалт хийхийн тулд уул уурхайн салбарыг Монголын эдийн засагт ямар ч хамаагүй юм шиг, хэрэггүй юм шиг, ашиг тусгүй юм шиг л яримааргүй байна.

Уул уурхайгаа ч дэмжье, бусад салбараа ч дэмжье. Бусад салбараа харин түлхүү дэмжье гэдэг ийм л зүйл рүүгээ хандаж яримаар байна. Нэг.

Дараагийн асуудал бол энэ дээр бид татварын ямар нэгэн юм нэмж өгөөгүй. Юм нэмж өгөөгүй. Одоо юу гэдэг юм гадаадад нь илүү хөнгөлөлт өгөөд, дотоодод нь бага өгнө гэсэн тийм зүйл байхгүй.

Татварын орчноор бид оролдоогүй. Яагаад гэвэл мэдээж ороод өөрчилбөл зөндөө л зүйл байх байсан.

Түүрүүн Х.Ганхуяг гишүүн асууж байсан. Ашигт малтмалын хуульдаа оруулах өөрчлөлтүүд нь. Өөр нэг гишүүн гэж асууж байсан. Хамт орж ирсэн үү гээд. Бид энэ удаа өргөөгүй. Яагаад гэвэл Ашигт малтмалын хуулийг Уул уурхайн яам өөрсдөө ажиллаж байгаа. Тэгээд бусад хүмүүсийн ажиллаж байгаа сэдэв рүү бид орж ирээд өөрчлөөд байх нь буруу гэж үзсэн учраас.

Бид өөр хүний эрхэлж байгаа, өөр сайдын эрхэлж байгаа асуудлууд руу орохгүйгээр энэ асуудлуудаа оруулж ирсэн гэдгийг хэлье.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлтэй холбоотой, шүүхтэй холбоотой. 100 хувь санал нэг байгаа.

Тэгэхээр Хөрөнгө оруулалтын тухай хуулиар бид тэр шүүгчид байдаг ч юм уу, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн асуудлыг шийдэх гэж оролдоогүй. Харин тэр асуудлыг хариуцаж байгаа хүмүүс тэр салбараа зөв болгохгүй бол удахгүй тэр салбар нь дампуурна шүү дээ.

Тэгэхээр тэр хүмүүс нь өөрсдөө энэ дээр илүү анхаарал тавьж яваад, хариуцсан хариуцсан ажлаа хүн болгон л зөв хийгээд явчих юм бол хөрөнгө оруулалтын таатай орчин үүснэ гэж үзэж байгаа.

Ийм ерөнхий зарчим, хандсан хандлага маань энэ юм шүү гэдгээ хэлье.

**Ц.Цэрэнпунцаг:** Т.Доржханд гишүүн тодруулж асуух уу? Т.Доржханд гишүүн тодруулж асууя.

**Т.Доржханд:** Ч.Хүрэлбаатар сайд аа, зөв зөв. Би тантай санал нэг байна. Гэхдээ хоёр зүйл.

Нэг дэх нь, уул уурхайн салбар чинь өөрөө каталистик үүрэгтэй буюу ийшээгээ хөрөнгө оруулалт хийж байж бусад салбар луу дамжиж туслан гүйцэтгэгч гэдэг юм уу, салбарууд ингэж орж ирж байгаа.

Оюу Толгойн гэрээ тодорхой жишээ. Тийм биз. Ийшээгээ хөрөнгө оруулалт татахгүй бол бусад салбар орж ирэхэд хэцүү гэдгийг та ч мэдэж байгаа, би ч мэдэж байгаа.

Түүнээс бүгдийг нь шууд хавтгайруулаад дэмжээд явна гэсэн бодлого байгаа юм уу? Эсвэл ач холбогдлын дараалал байгаа юм уу? Тэрийг нь тодруулчихмаар байна.

Уул уурхайн салбар, хөдөө аж ахуйн салбар, аялал жуулчлалын салбар ч гэдэг юм уу. Тийм биз.

Миний харж байгаа өнцөг хамгийн бодитой нь уул уурхайн салбар луугаа дэмжээд цаашаагаа энэ хувийн хэсэг хөрөнгө оруулалтыг дэмжээд явах нь зүйтэй юм гэдэг ийм нэг итгэл үнэмшил байгаад байгаа юм.

Хоёрт нь, гаднын хөрөнгө оруулалт чинь эхлээд санхүүгийн салбар луу хөрөнгө оруулалт хийдэг. Хамгийн түрүүн хардаг юм бол ханш шүү дээ. Ханшны тогтвортой байдал, макро тогтвортой байдал.

Инфляцын хувьд тодорхой.../минут дуусав/

**Ц.Цэрэнпунцаг:** Ч.Хүрэлбаатар сайд тодруулж нэмэлт хариулт өгье.

**Ч.Хүрэлбаатар:** Тийм. Ерөнхийдөө санал нэг.

Санхүүгийн салбарын хөрөнгө оруулалтын тухай асуудал.

Монгол Улсын эдийн засгийн чуулга уулзалт 7 сарын 09, 10-нд болно. Томоохон төлөөллүүд ирж байгаа.

Энэ дээр би юу ярьж байгаа вэ гэхээр өчигдөр ажлын хэсгийг нь хуралдахдаа би Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хорооныхонд ярьсан.

Та бүгд энэ чуулга уулзалтыг ашиглаад хөрөнгө оруулагч банк, банкны төлөөллүүдтэй уулзаад Монголд банк байгуулаач ээ гэж гуй.

Өөрсдөө дандаа юм гуйлгадаг юм шиг битгий байгаад бай. Одоо гуй, урь, хуулиа тайлбарла, өөрсдөө идэвхтэй ажилла. Тэгж байж энэ Монгол Улсад гаднын банкнууд орж ирж үйл ажиллагаа явуулна гэхээс биш өөрсдөө өөрөө өрөөндөө суучаад хэн намайг гуйж ирэх бол гээд суугаад байвал Монгол Улсад хөрөнгө оруулагч нар санхүүгийн салбарт орж ирэхгүй.

Жоохон тийм идэвхтэй, санаачилгатай ажиллаад өгөөч ээ гэж хэлсэн. Тэгээд тэр чуулга уулзалтын үеэр идэвхтэй ажиллахыг л хүссэн байгаа. Санал нэг байна.

**Ц.Цэрэнпунцаг:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Ингээд хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Х.Ганхуяг гишүүнээр, Т.Доржханд гишүүнээр тасалъя.

Х.Ганхуяг гишүүн үгээ хэлнэ үү.

**Х.Ганхуяг:** Яах вэ, угаасаа Их Хурал дээр хэлэлцээд эхлэхээр бид дутуунуудаа нөхөөд. Яах вэ, мэдээж хэрэг нэг өргөс авчихсан юм шиг бүгдийг нь шийдүүлж чадахгүй.

Гэхдээ бид хууль хууль дээр нь анхаараад явах нь зүйтэй л дээ.

Яах вэ, энэ завшааныг ашиглаад гэх юм уу, одоо бид гадаадад суугаа Элчин, төлөөлөгчийн газруудыг ер нь ямар нэгэн байдлаар жоохон үүрэгжүүлдэг болмоор байна.

Хөрөнгө оруулалтыг татах. Энэ чинь зөвхөн Эдийн засаг, хөгжлийн сайдын ажил биш шүү дээ.

Сая ярьж байна. Монголбанк явах ёстой, ингэх ёстой гээд. Монгол руу хөрөнгө оруулалтыг татах, гадаад худалдааны түншүүдийг бий болгох энэ тал дээр гадаадад суугаа тэр нэг амралтын газар гэж ойлгочихсон байгаа Элчин сайдуудыг, тэр худалдааны атташега нарыг энэ тал дээр үүрэгжүүлмээр байгаа юм.

Яг цалинтай нь, бонустай нь, тэнд ажиллах хугацаатай нь уяад КPI<sub>[key performance indicator-гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлт]</sub>-тай болгоод ингэж үүрэгжүүлэхгүй бол зүгээр очиж байгаа хувийн хэвшлээ яг л нэг улных гэж боддог. Харьцдаг ч үгүй, утсаа авдаг ч үгүй, уулзъя гээд цаг ч өгдөггүй.

Тэгээд энэ дээр яг бүр нэг онцгой анхаараад. Магадгүй Эдийн засгийн хөгжлийн яамны харьяа тэр худалдааны атташега нараа мэдэлд аваад, тэгээд үүрэгжүүлээд, тэгээд тэр хөрөнгө оруулалтын форум ч байдаг юм уу, хөрөнгө оруулагчийг татах ч байдаг юм уу, сурталчлах байдаг юм уу энэ ажлыг жоохон идэвхтэй болмоор байна.

Бид бүх оронд Элчин сайдын яамаа нээж чадахгүй ч бид бүх оронд худалдааны атташе, хөрөнгө оруулалтын атташе ч байдаг юм уу бий болгох боломжтой байхгүй юу.

Тэгж байж бид энэ нэг далайд гарцгүй гэдэг юмаа иймэрхүү гадаад харилцаагаараа нөхөж, гадаад идэвхтэй харилцаагаараа чармайдаг, хойноос нь хөөцөлддөг энэ харилцаагаа бид нөхөж явахгүй бол яг л ингээд нэг байран дээр нь нөхдөг.

Гадаад гэдэг юм орсон л байвал бүгдийг нь эсэргүүцдэг, жадлан эсэргүүцдэг.

Тэр англи хэлийг жадлан эсэргүүцнэ, гадаадын хөрөнгө оруулалтыг жадлан эсэргүүцнэ.

Энэ сэтгэхүйгээсээ бид салж явахгүй бол дандаа хоцорч яваад байгаа юм гэдгийг хэлэх гэсэн юм. Баярлалаа.

**Ц.Цэрэнпунцаг:** Т.Доржханд гишүүн үгээ хэлье.

**Т.Доржханд:** Би товчхон үг хэлчихье.

Яах вэ, нэгдүгээрт 1945 оноос хойш дэлхийн эдийн засагт маш том өөрчлөлт гарсан. Тэр өөрчлөлт нь юу вэ гэхээр өмнөх 2 мянган жил, түүнээс өмнөх дэлхийтэйгээ харьцуулах юм бол дэлхийн эдийн засаг 8 дахин өссөн байдаг юм. 8 дахин өссөн байдаг юм.

Дэлхийн хүн амын дундаж наслалт 20 жилээр өссөн байдаг. Дэлхийн хүн ам 2.3 тэрбумаас 8 тэрбум болсон байдаг. Дэлхийд өлсгөлөн байхгүй болчихсон, дайн байхгүй болчихсон.

Дэлхийн дайн бол хөрөнгө оруулалтын талбар дээр л явдаг болчихсон.

Хөрөнгө оруулалтыг татаж чадсан 200 улсын 40-өөд нь маш сайн хөгжчихсөн. Жадлан эсэргүүцдэг, ард түмэндээ таалагдах гэж популизм хийдэг, төслүүдээ явуулж чаддаггүй Африк, Латин Америк мэтийн маш олон улсууд нь хойноо хоцорчихсон.

Одоо монголчууд хөгжих юм уу, хөгжихгүй юм уу гэдэг яг энэ асуултдаа хариулмаар байх юм.



Ингэхийн тулд хөрөнгө оруулалтаа татаад хамтдаа хөгжье гэдэг энэ концепц дээрээ хатуу байгаад явмаар байгаа юм. Үүний тулд Үндсэн хуулийн өөрчлөлт хийгдсэн гэж ойлгож байгаа.

Хулгай ярьдаг биш, хөгжил дээрээ хамтардаг, том асуудал, том хөгжил дээрээ нэгдэж чаддаг ийм улс төрийн институцүүд парламент бий болоод засаг нь ажиллаасай гэж хүсэж байгаа юм.

Ийм агуулгаар Үндсэн хуулийг бас иргэдэд ойлгуулаад явсан. Ийм болохоор ирэх Засгийн газар илүү тогтвортой Засгийн газар байх болов уу гэж найдаж байгаа.

Харин ингэхийн тулд хөрөнгө оруулалтын орчин, түүнээс гадна бодлого чухал байна.

Эдийн засгийн хөгжлийн яам байгуулагдсан бас нэг чухал хийх ёстой зүйл бол энэ бодлогын эрэмбэ. Эрэмбэ юм шүү.

Түүн дээр харин та бүгдэд нэг зүйл хэлэхэд дэлхий яагаад хөгжчихсөн юм бэ гээд судлаад үзэхээр өөр өөрийн онцлогтой байгаа шүү. Манай судлаачдын гаргаж ирсэн **“Монгол хүний товчоон”** [Монгол хүний товчоон: Хүннү өвгөөс ХХI зуун. Б.Найдялаа, Д.Гангулга, Т.Доржханд; 2019] ГЭЭД ДЭЛХИЙН 200 улсын 28 улсыг жишсэн, харьцуулсан номыг та нар авч үзээрэй. Яг тэнд нь оршин суудаг, амьдардаг хүмүүс, судлаачид бичсэн байгаа.

Маш энгийнээр хэлэхэд уул уурхайгаар хөгжиж байгаа орнууд байна. Ямар тохиолдолд хөгжиж байна гэхээр хажууд нь зах зээл ойрхон байгаа тохиолдолд хөгжихөөд байгаа юм.

Канад яаж хөгжсөн юм, Австрали яаж хөгжсөн юм. Канад гэхэд бүгдээрээ мэдэж байгаа шүү дээ.

Америкийн эдийн засаг **“boom”** болоод л тийшээгээ юмаа зараад л хөгжсөн байдаг юм.

Австралийг бүгдээрээ мэдэж байгаа шүү дээ. Өнөөдөр ямар сайхан хот билээ гээд л монголчууд бүгдээрээ очоод байдаг. Гэтэл тэр чинь англичуудын гэмт хэрэгтнүүдийг явуулдаг **irish, scottish** хүмүүсийг явуулдаг тийм цөллөгийн л газар байсан шүү дээ. Дэлхийн мухарт байсан.

Японы эдийн засаг дэлхийн 3 номерын эдийн засаг болсон.

Араас нь Хятадын зах зээл бий болсон. Тийшээгээ одоо нөгөө нүүрснээсээ авахуулаад л хонь махныхаа нийлүүлэлтийг хийгээд л ингээд л босоод ирсэн шүү дээ. Шинэ Зеланд нарын.

Монголын эдийн засгийн модель ийм шүү. Ийм болохоор та нар загвар дээрээ эрэмбээ сайн тодорхой болгох хэрэгтэй.

Бүх л зүйлийг хөдөө аж ахуйн уламжлалтайгаа хийчихнэ. Тэгээд сайхан аялал жуулчлалаа аятайгаа үзүүлчихнэ гээд л бүгдэнг нь хавтгайруулаад л хүмүүст таалагдах байдлаар явах юм бол энэ чинь өөрөө буруу шүү.

Хаанаасаа эхлэх юм. Хөрөнгө оруулагчид яг аль салбар нь ашигтай юм. Бидний давуу тал юу юм. Энэ дээрээсээ үндэслээд бид хөрөнгө оруулалтынхаа бодлогыг гаргаж ирээд, тэгээд дараа нь энэ хуулийнхаа орчин дээр тусгаад явах нь зүйтэй шүү гэдгийг бүр хэлмээр санагдаад байна.

Зах зээлээ бий болгох зорилгоор сая Ерөнхий сайдын айлчлал сайн боллоо.



Одоо цаашаа бид хөрөнгө оруулалтаа татаад өөрсдөө хийж чадах юмаа хийгээд, чадахгүйгээ хамтраад, тэгээд урагшаагаа юмаа нийлүүлэх ийм л орчин байгаа юм.

Африкийн улсууд бид нараас илүү баялагтай шүү дээ. Баялаг гэдэг чинь газар нутгийн хэмжээгээрээ байдаг болохоос биш Монгол ганцаараа баялагтай биш шүү.

Дэлхийн хамгийн их баялагтай улс бол хамгийн том газар нутагтай Орос байдаг юм шүү. Америк байдаг юм. Хятадууд өөрсдөө байдаг юм. Канадууд байдаг юм. Австралидууд байдаг юм.

Харин хаана зах зээл ойрхон байна вэ гэдгээсээ хамаараад хөгжлийн энэ асуудал чинь өөр байдаг юм шүү.

Африкт биднээс илүү баян улсууд байдаг мөртлөө нэг, хоёр улсыг даваад цаашаа тив алгасаад очоод нүүрсээ, зэсээ гээд зарна гэхээр л үнэтэй болчихдог байхгүй юу.

Тийм болохоор тэд нар хамгийн бага зардлаар тээвэрлэдэг алмазынхаа үйлдвэрлэлийг хийдэг, алтныхаа үйлдвэрлэлийг хийдэг.

Монголд бол өнөөдөр эсрэгээрээ ийм том давуу талтай байхгүй юу. Ийшээгээ чиглэсэн бодлого руугаа та нар орж байж мөнгөө олоод бусад салбараа санхүүжүүлдэг систем рүүгээ орохгүй бол бүгдээрээ сайхан наашаа бүх салбар луу ор гэсэн ийм адилтгал бол популизм шүү.

Мэргэжилтнүүд, эдийн засагчид, макро эдийн засагчид, хөгжлийн эдийн засагчид байгаа л юм бол хөгжлийнхөө загваруудыг судлаад яг ийшээ прагматик шийдвэрүүдээ гаргаад орох нь зүйтэй шүү.

Одоо бүгдээрээ ерөнхийгөөс илүү деталь руу ордог ийм байдал руу манай Хөгжлийн яам илүү анхаараад.../минут дуусав/

**Ц.Цэрэнпунцаг:** Манай гишүүд асуулт асууж, санал, үгээ хэллээ.

Байнгын хорооны гишүүд бүгд энэ хуулийн хэлэлцэх эсэхийг дэмжиж хэлэлцье гэж байгаа. Би ч гэсэн энэ хуулийн хэлэлцэхийг дэмжиж байна.

Тэгээд нэг санал хэлчихье гэж бодож байна. Манайх Эдийн засгийн хөгжлийн яамтай болсон. Хөгжлийн бодлоготой, хуультай болчихсон.

Тэгээд энэ яам маань шинээр байгуулагдаад, Ч.Хүрэлбаатар сайд туршлагатай сайд энэ яамаа удирдаад. Энэ сайхан залуу боловсон хүчин, шижигнэсэн залуучуудаас бүрдүүлчихсэн. Хөгжлийн модель загварууд сайхан гарч, тодорхой болж.

Үүнийх нь хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх ажлууд их цэгцтэй сайхан явж байгаа гэж харж байгаа.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хууль дээр Г.Түвдэндорж дэд сайд бид сайхан хамтарч ажиллаад гарсан. Тийм ээ.

Гадаадын банкны хууль ч гарсан байгаа. Тэгээд үүний дараа Хөрөнгө оруулалтын хууль ирж байгаа бол яг одоо эрэмбэ дарааллаараа хууль, эрх зүйн орчинд бүрдэх ёстой бүрэлдэхүүн хэсгүүд сайхан бүрэлдэж явж байгаа юм байна.

Биржийн хууль гарсан. Тийм.

Тэгэхээр зэрэг энэ ер нь бас Хөрөнгө оруулалтын хуулийг бид энэ

хөгжлийнхөө бодлогын гол суурь хууль гэж ингэж харах ёстой.

Тийм учраас ерөнхий гол зарчмынхаа асуудлуудыг энд тусгасан байр ёстой гэж харж байгаа. Би энэ өнцгөөс харж байгаа учраас хуулийг ерөнхийдөө сайхан төсөл болж гэж харж байгаа.

Тэгэхдээ мэдээж сайжруулах, гүнзгийрүүлэх ажлын хэсэг гарна. Энэ ажлын хэсгийн бүрэлдэхүүн олон өнцгөөс нь харж ажиллах гишүүдээ оруулья гэж бодож байгаа.

Тийм учраас Т.Доржханд гишүүн, О.Цогтгэрэл гишүүн, бусад гишүүд ажлын хэсэгт орж ажиллаарай гэж та бүхэндээ давхар хэлье.

Манай Засгийн газар том зорилт тавьсан. 2030 он гэхэд нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүнийг америк доллароор 10 мянгад хүргэнэ гэж манай Ерөнхий сайд Их Хурлын индэр дээрээс хэлсэн. Тийм ээ.

Энэ бол бид нарын том зорилго байр ёстой. Өнөөдөр 5 мянга дөнгөж давж алхсан шүү дээ. Тийм ээ. Энэ жил анх удаа.

Үүнийгээ бид хоёр дахин нэмье гэж байгаа энэ үед гарцаа байхгүй бидэнд энэ эдийн засгийн том өсөлтийг авчрах төслүүд байна уу. Байна. Тийм багтаамж байна уу. Байна. Тийм том дэд бүтцүүд байна уу. Байна. Тийм төслүүд байвал байна.

Тэгэхдээ үүнийг хэрэгжүүлдэг ганц л зүйл байгаа. Тийм ээ. Гол хэрэгтэй зүйл нь бидэнд дутагддаг. Энэ нь төсвөөс гаргах боломжгүй. Дотоодынхоо нийт хуримтлалыг аваад үзсэн ч эндээс гарах боломжгүй учраас гарцаа байхгүй бид

гадагшаа гарч үүнийгээ хайж авчрах ёстой.

Тийм учраас бидэнд яг хэрэгтэй байгаа энэ капиталыг авчрах улсууддаа бид зориулж хууль хийж байгаа гэж харж байгаа.

Тэгэхээр энэ хуульд олон боломжийг нээж өгсөн. Хууль тодорхой байр ёстой. Сая гишүүдээс ярьж байна. Тодорхой олон асуудлууд байгаа. Мэдээж ханш гэдэг эрсдэл байгаа гээд.

Тэгэхдээ эрсдэл олон төрлийн эрсдэл байгаа. Хөрөнгө оруулалт хийх хөрөнгө оруулагчид бизнестийн эрсдэлийг удирдах, эрсдэлээс хамгаалах. Энэ нь бизнесийн удирдлага, бизнесийн менежерүүдийн ур чадвартай холбоотой асуудал.

Монгол Улсын хувьд хөрөнгө оруулалтын орчин, улс төрийн байдал тогтвортой байх ёстой. Хууль нь тодорхой байх ёстой. Хууль өөрчлөгддөггүй байх ёстой.

Энэ хуулийг хараад хөрөнгө оруулалтаа оруулсан хөрөнгө оруулагчид хуулийнхаа дагуу аль аль талдаа үүргээ хүлээдэг, хариуцлагаа хүлээдэг.

Тодорхой бичигдсэн хуулиа хуулийг бариад сүүлд нь маргаан гараад шийдвэрлэхэд энэ шийдвэрлэж байгаа үйл явц нь шударга байр ёстой.

Ийм л зүйлийг гадаадын хөрөнгө оруулагчид голлож харж байгаа. Энэ нь өнгөрсөн жилүүдэд бидний гаргасан алдаатай ч холбоотой.

Одоо бидэнд дахиад хоёр дахь боломж олдож байна. Тийм ээ.

Одоо ирж сонирхож байгаа, манай Засгийн газартай, яамдтай ирж уулзаж

байгаа хөрөнгө оруулалт хийе гэж сонирхож яваа хөрөнгө оруулагчдаас шууд өөрсдийнх нь гол санаа зовоож байгаа зүйлийг асуухад энэ асуудал байна л гэж байгаа юм.

Энэ ямар нэгэн тийм хийсвэр судалгаа, онолын зүйл биш. Яг бодит, практик амьдрал дээр байгаа.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хууль байж байна. Том хөрөнгө оруулалтууд зарлалаа. Тийм үү. Том зорилтууд тавьчихлаа гээд.

Энэ том хөрөнгө оруулалтууд чинь хөрөнгө оруулалт хийе гээд бодитой хөрөнгө оруулагчидтай уулзчихна шүү дээ.

Энэ хүмүүсийн тавьж байгаа гол санаа зовж байгаа зүйлүүдийг яаж шийдэж болох вэ, энэ орц, гарцаа шийдэж гаргаж байгаа хууль учраас амьдрал дээр, хөрсөн дээрээ буусан практик амьдралд нийцтэй хууль гарах байх гэж харж байгаа юм.

Тэгээд мэдээж бид өнөөдөр нэг сайн хууль гаргаад бүх асуудлыг шийдчихгүй. Тийм ээ.

Санал хураалт явуулж эхэлье.

Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 66.7 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Санал хураалт явуулж дууслаа.

Хуулийн төслийг хэлэлцсэн хэлэлцсэн талаар Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг танилцуулна.

Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг дууслаа.

Дараагийн асуудалдаа орёе.

Хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоол төслийг танилцуулъя.

Ажлын хэсгийн ажлын хэсэг байгуулах тухай.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5 дахь хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуягаар ахлуулан байгуулсугай.

2.Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллагын мэргэжлийн албан хаагчдыг ажиллуулахыг ажлын хэсэг Х.Ганхуягт зөвшөөрсүгэй.

Тогтоолын төсөл дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Санал хураалт явуулъя.

“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолыг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 58.3 хувь нь дэмжиж санал дэмжигдлээ.

Санал хураалт явуулж дууслаа. Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Дараагийн асуудалдаа орёе.

---

**Тав.Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, “Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл**  
*/Засгийн газар 2023.06.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ/*

---

Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайлан, “Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцүүлгийг явуулъя.

Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Наранчимэг танилцуулна. Ажлын хэсгийн 3 номерын микрофон нээе.

**Ц.Наранчимэг:** Байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын тухай хуульд заасан бүрэн эрх, Төсвийн тухай хуулийн дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тус Байнгын хороонд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл болон улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнд хийсэн аудитын талаар төсвийн ерөнхийлөн захирагч бүрээр товч танилцуулъя.

Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан 4 байгуулгын санхүүгийн тайлан нэгтгэгдэж өөрчлөлтгүй санал, дүгнэлтийг өгсөн бөгөөд харьяа 1 байгууллагад хязгаарлалттай санал, дүгнэлтийг өглөө.

Нийт 0.4 тэрбум төгрөгийн 14 зөрчил илэрснээс 1 төлбөрийн акт тогтоож, 0.1 тэрбум төгрөгийн 5 албан шаардлага хүргүүлж, 0.3 тэрбум төгрөгийн 8 зөвлөмжийг өглөө.

Нийцлийн асуудлаар 6.6 тэрбум төгрөгийн 8 зөрчил илэрснээс 6.4 тэрбум төгрөгийн 4 албан шаардлага, 0.2 тэрбум төгрөгийн 4 зөвлөмж өгсөн болно.

Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 24.3 тэрбум төгрөгийн алдааг аудитын явцад бүрэн залрууллаа.

Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан 33 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 26 байгууллагад дүгнэлт гаргаж, 7 байгууллагыг түүвэрт хамрууллаа.

Аудитаар хязгаарлалттай санал, дүгнэлт өгсөн бөгөөд харьяа 21 байгууллагад өөрчлөлтгүй, 4 байгууллагад хязгаарлалттай, 1 байгууллагад сөрөг дүгнэлт өгч нийт 520.7 тэрбум төгрөгийн 97 зөрчил илэрснээс 0.1 тэрбум төгрөгийн 14 төлбөрийн акт тогтоож, 516.3 тэрбум төгрөгийн 38 албан шаардлага хүргүүлж, 2.6 тэрбум төгрөгийн 42 зөвлөмж, 1.7 тэрбум төгрөгийн 3 зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн болно.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаагүй 1.3 тэрбум төгрөгийн зөрчил гаргасан 13 байгууллагын төсөвт захирагч нарт хариуцлага тооцуулах албан шаардлагыг хүргүүллээ.

Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 342.3 тэрбум төгрөгийн 28 алдаа илэрснээс аудитын явцад 291.1 тэрбум төгрөгийн 23 алдааг залруулж, 51.2 тэрбум төгрөгийн алдааг давтан гаргахгүй байх 5 зөвлөмжийг өглөө.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 25 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 21

байгууллагад дүгнэлт гаргаж, 4 байгууллагыг түүвэрт хамрууллаа.

Аудитаар хязгаарлалттай санал, дүгнэлт өгсөн бөгөөд харьяа 9 байгууллагад хязгаарлалттай, 3 байгууллагад сөрөг дүгнэлтийг өгч, нийт 2.4 их наяд төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 10 тэрбум төгрөгийн 22 төлбөрийн акт тогтоож, 516.2 тэрбум төгрөгийн 84 албан шаардлага хүргүүлж, 1.9 их наяд төгрөгийн 62 зөвлөмж өгч, эрхэлсэн ажилдаа хариуцлагагүй хандсан албан хаагчдад хариуцлага тооцуулах албан шаардлагыг хүргүүлж хууль хяналтын байгууллагад 2 байгууллагын 27 тэрбум төгрөгийн асуудлыг шилжүүллээ.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаагүй 1.2 тэрбум төгрөгийн зөрчил гаргасан 17 байгууллагын төсвийн захирагч нарт хариуцлага тооцох албан шаардлагыг хүргүүлсэн.

Нягтлан бодох, бүртгэл тайлагналтай холбоотой 3 их наяд төгрөгийн 83 алдаа илэрснээс аудитын явцад 65 алдааг залруулж, нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 28.6 тэрбум төгрөгийн 18 алдааг давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 33 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэсэнээс 32 байгууллага дүгнэлт гаргаж, 1 байгууллагыг аудитын түүвэрт хамрууллаа.

Аудитаар хязгаарлалттай санал, дүгнэлт өгсөн бөгөөд харьяа 25 байгууллагад өөрчлөлтгүй, 7 байгууллагад хязгаарлалттай дүгнэлт өгч, нийт 110.3 тэрбум төгрөгийн 156 зөрчил илэрснээс 0.5 сая төгрөгийн 25 төлбөрийн

акт тогтоож, 94.4 тэрбум төгрөгийн 67 албан шаардлага хүргүүлж, 5.4 тэрбум төгрөгийн 61 зөвлөмж, эрхэлсэн ажилдаа хариуцлагагүй хандсан 2 зөрчилд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлж, хууль хяналтын байгууллагад 1 асуудлыг шилжүүлсэн болно.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаагүй 7.7 тэрбум төгрөгийн зөрчил гаргасан 8 байгууллагын төсөв захирагч нарт хариуцлага тооцуулах албан шаардлагыг хүргүүллээ.

Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 547.1 тэрбум төгрөгийн 101 алдаа илэрснээс аудитын явцад 541.8 тэрбум төгрөгийн 82 алдааг залруулж, нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 5.3 тэрбум төгрөгийн 19 алдааг давтан гаргахгүй байх зөвлөмжийг өглөө.

Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 33 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэснээс 31 байгууллага дүгнэлт гаргаж, 2 байгууллагыг аудитын түүвэрт хамрууллаа.

Аудитаар хязгаарлалттай санал, дүгнэлт өгсөн бөгөөд харьяа 19 байгууллагад өөрчлөлтгүй, 12 байгууллагад хязгаарлалттай дүгнэлт өгч, нийт 143 тэрбум төгрөгийн 268 зөрчил илэрснээс 0.2 тэрбум төгрөгийн зөрчилд 42 төлбөрийн акт тогтоож, 138.5 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах 94 албан шаардлага, 4.1 тэрбум төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 124 зөвлөмж, хариуцлага тооцуулах 6 албан шаардлага, 0.2 тэрбум төгрөгийн 2 асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүллээ.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаагүй 9.8 тэрбум төгрөгийн зөрчил гаргасан 18 байгууллагын төсөв захирагч нарт хариуцлага тооцох албан шаардлагыг хүргүүлсэн болно.

Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 85.2 тэрбум төгрөгийн 82 алдаа илэрсний 84.7 тэрбум төгрөгийн 73 алдааг аудитын явцад залруулж, 0.5 тэрбум төгрөгийн 9 алдааг давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Санхүүгийн зохицуулах хорооны даргын төсвийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн бөгөөд аудитаар нийт 0.9 тэрбум төгрөгийн 4 зөрчил илэрснээс 3 албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмжийг өгсөн болно.

Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 23 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэснээс 18 байгууллага дүгнэлт гаргаж, 5 байгууллагыг түүвэрт хамрууллаа.

Аудитаар хязгаарлалттай санал, дүгнэлт өгсөн бөгөөд нийт харьяа 18 байгууллагад өөрчлөлтгүй дүгнэлт өгч, 0.9 тэрбум төгрөгийн 34 зөрчил илэрснээс 8 албан шаардлага, 8 төлбөрийн акт, 16 зөвлөмж өгч, хариуцлага тооцуулах 2 албан шаардлагыг өглөө.

Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 0.5 тэрбум төгрөгийн 18 алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа.

Аудитын дүн, дүгнэлтээс тус Байнгын хороонд харьяалагдах төсвийн



ерөнхийлөн захирагч нарын анхаарах асуудлыг Та бүхэнд танилцуулья.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлсэн хөтөлбөр, хөтөлбөрийн үр дүн, чанар, тоон хэмжээг төсвийн гүйцэтгэлтэй уялдуулан хяналт шинжилгээ, үнэлгээ хийж баталгаажуулахгүй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн тодорхойгүйгээс улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнг бодитой үнэлэх боломжгүй байна.

Төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, хэрэгжилтэд тавьж буй захиалагчийн болон зохиогчийн хяналт үр дүнгүй, төсвийн ерөнхийлөн захирагчдын дотоод аудитын нэгж нь хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд хяналт хийхгүй байгаа нь зөрчил арилахгүй байх гол шалтгаан болж байна.

Засгийн газрын шийдвэрээр төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүд төсвөөс санхүүжих нийгмийн чанартай төсөл, арга хэмжээ, бүтээн байгуулалтын ажлуудыг санхүүжилт байгаа нь төсвийн нэгдсэн бодлогын зарчмыг алдагдуулж байна.

Төсөвлөлтийн шаардлага хангахгүй төсөл, арга хэмжээг санхүүжүүлж байгаа нь хөрөнгө оруулалтын үр өгөөж буурах, мөн төсөвт ачаалал үүсгэж буй талаар жил бүр хийгдэж буй аудитын дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэхгүй байгаа нь Төсвийн тухай хуульд заасан төсөвлөлтийн шаардлагыг хангахгүй байна.

Харьяа төсвийн ерөнхийлөн захирагчдын үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулж, төрийн аудитын байгууллагаас гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг хангуулж ажиллахыг зөвлөж байна.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Ц.Цэрэнпунцаг:** Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулья.

Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Сангийн сайд Б.Жавхлан, Ц.Наранчимэг Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Я.Самбууням Аудитын нэгдсэн удирдлага зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор, Д.Энхболд Гүйцэтгэл нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор. Бусад холбогдох албан тушаалтнууд оролцож байна.

2022 оны төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон аудитын дүгнэлттэй холбогдуулан төслийн талаар асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна.

Гишүүд асуулт асууж дууслаа. Үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. Гишүүд асуулт асууж үг хэлж дууслаа.

Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгдсэн тайланг хэлэлцсэн талаар талаарх Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны гишүүн Д.Өнөрболор танилцуулна.



Төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэж  
дууслаа. /алх цохив/

Идэвхтэй оролцсон гишүүддээ  
баярлалаа.

Эдийн засгийн байнгын хорооны  
өнөөдрийн хуралдаан үүгээр өндөрлөж  
байна.

*Хуралдаан 2 цаг 38 минут үргэлжилж, 14 цаг 18 минутад өндөрлөв.*

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

**Ц.АЛТАН-ОД**